ЭМД
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2022-2024 ОНЫ СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ

Улаанбаатар хот
2025 он

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

Байгууллагын РД:6263305

Монгол Улс, Улаанбаатар хот, Хан–Уул дүүргийн 20 дугаар хороо

976–70100005

www.emd.gov.mn

info@emd.gov.mn

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар

@EMDaatgal

Eruul_mendiin_daatgal

Чингисийн өргөн чөлөө, Хан–Уул дүүрэг, Улаанбаатар–17032

Санхүүгийн жил: 2022–2024 он

Тайланг эрхэлсэн:

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Ц.Батбаатар

Тайланг эмхэтгэсэн:

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын “Статистик эмхэтгэл боловсруулах”

Ажлын хэсгийн ахлагч Б.Батчимэг

Ажлын хэсгийн нарийн бичиг С.Сувдмаа

Ажлын хэсгийн гишүүд

“АРВАЙ БАРХАН” ХХК–д эхийг бэлтгэж хэвлэв.

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ 4

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ 5

ЗУРГИЙН ЖАГСААЛТ 6

ӨМНӨХ ҮГ 7

1. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЗАРЧИМ, ҮНЭТ ЗҮЙЛ, АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО 8

2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ 9

3. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ТЭНЦЭЛ, ҮР ДҮН 13

3.1. Эрүүл мэндийн даатгалын хамралт. 13

3.2. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого. 15

3.3. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага. 20

4. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ХУДАЛДАН АВЧ БАЙГАА ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР 26

4.1.Анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ. 26

4.2.Лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ. 31

4.3.Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тусламж, үйлчилгээ. 34

4.4.Эмийн үнийн хөнгөлөлт. 37

4.5. Төрөөс төлбөрийг нь хариуцах эмийн гүйцэтгэл. 40

4.6. Новартис эмийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр 42

5. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ДААТГУУЛАГЧДЫН ҮЗҮҮЛЭЛТ БА ҮР ДҮН 44

6. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, ГЭРЭЭЛЭЛТ 54

7. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ 56

8. ИРГЭД, ОЛОН НИЙТЭД ЧИГЛЭСЭН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ 59

Хавсралт 1. 62

Хавсралт 2. 69

Хавсралт 3 73

Хавсралт 4. 74

Хавсралт 5. 78

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуй нэгж
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	Засгийн Газар
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ОХБ	Оношийн хамааралтай бүлэг
ӨСТЭМТ	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СТЭМТ	Сум, тосгоны эрүүл мэндийн төв
СЭМТ	Сумын эрүүл мэндийн төв
ТӨЭМБ	Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага
ТУ	Тусламж үйлчилгээ
УИХ	Улсын Их Хурал
ЦТЭ	Цэргийн төв эмнэлэг
ХХДХ	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭЭС	Эргэлтийн эмийн сан

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Эрүүл мэндийн даатгалын сангийн үндсэн үзүүлэлт, оноор	9
Хүснэгт 2.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчийн тоо (давхардаагүй)	10
Хүснэгт 3.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл (сая.төг)	11
Хүснэгт 4.	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчдын тоо	14
Хүснэгт 5.	Эрүүл мэндийн даатгалд хамгийн бага хамрагдсан бүлэг	15
Хүснэгт 6.	Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ	
Хүснэгт 7.	Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын гүйцэтгэл (сая.төг.)	15
Хүснэгт.8.	Даатгуулагчийн төлсөн шимтгэлийн орлого, даатгуулагчийн төрлөөр (сая.төг)	16
Хүснэгт 9.	Төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс олгох хөрөнгө (сая.төг)	18
Хүснэгт 10.	Бусад орлого, төрлөөр (сая.төг)	19
Хүснэгт 11.	Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12.1.1–д заасны дагуу нөхөн төлбөрийн дүн, оноор (сая.төг)	19
Хүснэгт 12.	Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын тойм (сая.төг)	20
Хүснэгт 13.	Эрүүл мэндийн даатгалын сангийн зардлын гүйцэтгэл (сая.төг)	21
Хүснэгт 14.	Нэг даатгуулагчид ногдох эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний дундаж зардал, насны бүлгээр, 2024 он(мян.төг)	23
Хүснэгт 15.	Эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээний төрөл, эзлэх хувь оноор	23
Хүснэгт 16.	Эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл, оноор (сая.төг)	24
Хүснэгт 17.	Эрсдэлийн сангийн гүйцэтгэл, зориулалт (сая.төг)	24
Хүснэгт 18.	Эрүүл мэндийн даатгалын сангийн тэнцэл (сая.төг)	25
Хүснэгт 19.	Анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт, эрүүл мэндийн байгууллагын төрлөөр (сая.төг)	27
Хүснэгт 20.	Анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл (сая.төг)	27
Хүснэгт 21.	Нэг иргэнээр тооцсон тусламж, үйлчилгээний гүйцэтгэл (сая.төг)	28
Хүснэгт 22.	Нэг иргэнээр санхүүжих гүйцэтгэлийн шалгуурын үнэлгээ, хүний тоогоор	28
Хүснэгт 23.	Анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, гүйцэтгэл (сая.төг)	30
Хүснэгт 24.	Лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, нэр төрлөөр (сая.төг)	31
Хүснэгт 25.	Лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, эрүүл мэндийн байгууллагын төрлөөр (сая.төг)	33
Хүснэгт 26.	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээний тоо, (давхардсан)	35
Хүснэгт 27.	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээний тоо, 2024 он	36
Хүснэгт 28.	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт олгосон санхүүжилт, багцын эзлэх хувь	36
Хүснэгт 29.	Эмийн үнийн хөнгөлөлтийн хүртээмж	37
Хүснэгт 30.	Эмийн үнийн хөнгөлөлтийн гүйцэтгэл (сая.төг)	37
Хүснэгт 31.	Эмийн үнийн хөнгөлөлт, хөнгөлөлтийн хувиар (сая.төг)	39
Хүснэгт 32.	Төрөөс төлбөрийг нь хариуцах эмийн санхүүжилт	40
Хүснэгт 33.	Төлбөрийг нь төр хариуцах өвчний үед хэрэглэгдэх эм, эрүүл мэндийн байгууллагуудын нэхэмжлэл	41
Хүснэгт 34.	Уналт, таталт өвчний үед хэрэглэгдсэн эмийн нэр төрөл, санхүүжилт	42
Хүснэгт 35.	Новартис эмийн хүний тоо, тохиолдол, санхүүжилт 2023–2024 он	43

Хүснэгт 36. Эмзэг бүлгийн хүн амыг хамтын төлбөрөөс чөлөөлсөн байдал (тэрбум.төг) 45
Хүснэгт 37. Зарим нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын тоо, харьцуулсан хувь 46
Хүснэгт 38. Эмийн үнийн хөнгөлөлт, даатгуулагчийн төрлөөр (сая.төг) 52
Хүснэгт 39. Гэрээт эрүүл мэндийн байгууллагын тоо 54
Хүснэгт 40. Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын тоо, 2024 оноор 55
Хүснэгт 41. Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний нарийвчилсан хяналтаар хянагдсан түүврийн тоо 56
Хүснэгт 42. Лавлагаа шатлалын нийт нэхэмжлэлд хасагдлын хувь 57
Хүснэгт 43. Лавлагаа шатлалын тусламж үйлчилгээний нарийвчилсан хяналтаар хасагдсан зөрчлийн сангийн бүртгэл, эзлэх хувиар 58
Хүснэгт 44. Тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахаар хүргүүлсэн зөвлөмжийн тоо 58
Хүснэгт 45. Даатгуулагч, иргэдийг мэдээллээр хангах контент боловсруулалтын статистик (давхардсан тоогоор) 59
Хүснэгт 46. ЗГ–ын Иргэд, олон нийттэй харилцах 11–11 төвийн утсаар дамжуулан эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тоо 60
Хүснэгт 47. Хэрэглэгчтэй харилцах төвийн дуудлагын тоо 60
Хүснэгт 48. Иргэн даатгуулагчдад олгосон буцаан олголт (мян.төг) 61

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд олгосон санхүүжилт, эзлэх хувь 12
Зураг 2. Даатгуулагчийн бүтэц, даатгуулагчийн төрөл, хувь, 2024 оны байдлаар 13
Зураг 3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нийт зардалд эзлэх хувь 22
Зураг 4. Нэг иргэнээр тооцсон санхүүжилтээр 2023, 2024 онд үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, эзлэх хувь 28
Зураг 5. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн дундаж оноо, нийт 80 онооноос, 2023–2024 он 29
Зураг 6. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад олгосон санхүүжилт (тэрбум mөг) 33
Зураг 7. Эрүүл мэндийн даатгалын сангийн үр ашгийн байдал 45
Зураг 8 Даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлсэн орлого, зардлын эзлэх хувь 47
Зураг 9. Өдрийн эмчилгээний тусламж, үйлчилгээ авсан даатгуулагч, эрүүл мэндийн байгууллагын төрлөөр, шимтгэл төлөлтийн төрлөөр 48
Зураг 10. 2024 онд гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчдыг шимтгэл төлөлтийн төрлөөр 48
Зураг 11. 2024 онд сэргээн засах тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчдыг шимтгэл төлөлтийн төрлөөр 49
Зураг 12. 2024 онд оношилгоо, шинжилгээ хийлгэсэн даатгуулагчдыг шимтгэл төлөлтийн төрлөөр 49
Зураг 13. 2024 онд лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчдыг шимтгэл төлөлтийн төрлөөр 50
Зураг 14. 2024 онд лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээнд хамрагдсан тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэд болон 0–18 насны хүүхдийн авсан тусламж, үйлчилгээний нэр төрөл, эзлэх хувь 51
Зураг 15. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн хамрагдалтын хувь, нас, нийт хүн амаар 51
Зураг 16. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээний хамрагдалт, даатгуулагчийн төрөл 52

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээг гэрээт эрүүл мэндийн байгууллагаас худалдан авах үйл ажиллагааг хариуцаж ажилладаг.

Энэхүү эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагааны статистик үзүүлэлт 2024 оны эмхэтгэл нь эрүүл мэндийн даатгалын санд цугларсан шимтгэлийн орлого болон төрөөс хариуцах тусламж, үйлчилгээнд олгох улсын төсвийн санхүүжилтийг иргэдэд ямар төрлийн тусламж, үйлчилгээг худалдан авахад зарцуулсан эсэх, ямар үр дүн гарч байгааг “даатгуулагчдадаа” ил тод нээлттэй тайлагнах, мөн шийдвэр гаргах түвшний удирдах ажилтан, эрдэмтэн, судлаач нарт тогтмол ашиглах гарын авлага болгох зорилгоор боловсруулж, та бүхэндээ хүргэж байна.

Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын сангийн цахим системд цугларсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийн их өгөгдөл дээр тулгуурлан олон улсын эрүүл мэндийн даатгалын байгууллагуудаас эрхлэн гаргадаг статистик үзүүлэлтийн жишгийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагааны статистик үзүүлэлтийг эмхэтгэн тайлагнаж байна. Түүнчлэн эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай үзүүлэх зорилгоор байгууллагаас үзүүлэх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, иргэд e–mongolia, e–barimt, e–daatgal аппликэйшнээр эрүүл мэндийн даатгалын бүх төрлийн үйлчилгээг авах боломжийг нээсэн билээ.

Монгол Улс “Эв санааны зарчим”–д суурилсан эрүүл мэндийн даатгалын тогтолцоог хэрэгжүүлдэг тул таны төлсөн шимтгэл таны эрүүл мэндийг хамгаалахад зарцуулагдаад зогсохгүй таны үр хүүхэд, эцэг, эх, орлого багатай эмзэг бүлгийн иргэд, хүнд өвчин туссан иргэдийн эрүүл мэндийн санхүүгийн эрсдэлийг хуваалцдаг чухал ач холбогдолтой юм. Иймд даатгуулагчдын төлсөн шимтгэлийн мөнгө зөвхөн тухайн иргэнд зарцуулагдахаас гадна өөр бусад иргэдийн санхүүгийн эрсдэлийг хуваалцдаг талаар үнэн зөв бодит мэдээллийг авахад энэхүү статистик үзүүлэлт уншигчдад тус болно гэж үзэж байна.

Цаашид бид Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас дэвшүүлж буй “Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад хүрэх зорилт”–ыг хангахад шаардлагатай арга хэмжээнүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлж, жил бүрийн “Эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагааны статистик үзүүлэлт” эмхэтгэлд тусган та бүхний хүртээл болгон ажиллах болно.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН

ДАРГА Ц.БАТБААТАР

1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЗАРЧИМ, ҮНЭТ ЗҮЙЛ, АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО

Эрүүл мэндийн даатгалын зарчим:

Эрүүл мэндийн албан журмын даатгал нь даатгуулагчийн төлсөн шимтгэлийн хэмжээнээс үл хамааран эрүүл мэндийн улмаас даатгуулагчид үүссэн санхүүгийн эрсдэлийг хуваалцах эв санааны нэгдлийн зарчимд тулгуурлана.

Эрүүл мэндийн даатгалын үнэт зүйлс:

- Даатгуулагчийн дээдэлсэн, үйлчлүүлэгч төвтэй байх;
- Бүх нийтийг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулах;
- Тэгш хүртээмжтэй байх;
- Нээлттэй байж хариуцлагаа бүрэн ухамсарлан ажиллах;
- Мэргэшсэн, өндөр чадвартай байх;
- Шинийг эрэлхийлэгч байх.

Эрүүл мэндийн даатгалын алсын хараа:

Даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг худалдан авдаг, хэрэглэгч, үйлчлүүлэгч төвтэй, нийгмийн хариуцлага бүхий эрүүл мэндийн даатгалын бие даасан тогтолцоог бүрдүүлэх.

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын эрхэм, зорилго:

Монгол хүн бүрийг эрүүл мэндийн даатгалд хамруулж, даатгалын тогтвортой санг бүрдүүлэн, даатгуулагчийн хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг худалдан авдаг үйлчлүүлэгч, төвтэй нийгмийн хариуцлага бүхий менежментийг хэрэгжүүлэхэд оршино.

2 ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

Монгол Улс эрүүл мэндийн салбарын улсын зардлын хэмжээг ДНБ–ний 5 хувьд, Засгийн газрын зардлын хэмжээг 12 хувьд хүргэх бодлогын зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

2023 оны байдлаар Эрүүл мэндийн зардлын ДНБ–д эзлэх хувь 2.8 байгаа нь өнгөрсөн оноос 0.2 функтээр, Засгийн газрын зардалд эзлэх хувь 8.1 байгаа нь өнгөрсөн оноос 1.0 функтээр буурсан үзүүлэлттэй байна. Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэл хэрэгжсэнээс хойш 2021 онд хамгийн өндөр буюу ДНБ–нд эзлэх хувь 4.6, Засгийн газрын зардлын эзлэх хувь 12.8–д хүрсэн нь Коронавируст халдварын өвчлөлтэй холбоотойгоор гадаадын зээл тусламжийн санхүүжилт болон эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт эрс нэмэгдсэнтэй холбоотой байсан.

Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан, бүс нутгийн болон иргэдийн эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээнд үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудаас тусламж, үйлчилгээг худалдан авах, гэрээлэх, тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд чанар, төлбөрийн хяналтыг хийж санхүүжүүлэх тогтолцоог хэрэгжүүлж байна.

Хүснэгт 1. Эрүүл мэндийн даатгалын сангийн үндсэн үзүүлэлт, оноор

Нэр	МД	2021 он	2022 он	2023 он	2024 он	Өөрчлөлтийн хувь
А	Б	1	2	3	4	5=(4–3)/3
Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо	1	3,057,087	3,200,502	3,240,219	3,274,958	1.1%
Эрүүл мэндийн даатгалын хамралтын хувь	2	89.7%	92.6	92.5%	93.4%	1.0%
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого (сая. төг)	3	985,745	1,560,013	1,608,715	2,025,826	25.9%
Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага (гүйцэтгэл), (сая. төг)	4	1,461,343	1,580,202	1,780,537	2,129,363	19.6%
Үйл ажиллагааны зардал (сая. төг)	5	7,543	13,282	10,286	15,049	46.3%
ДНБ–д эрүүл мэндийн салбарын зардлын эзлэх хувь	6	4.6%	3.3%	3.0%	2.8%	–6.7%
Засгийн газрын нийт зардалд эзлэх эрүүл мэндийн даатгалын сангийн зардлын хувь	7	12.8%	9.9%	9.1%	8.1%	–11.0%

Эрүүл мэндийн даатгалын сангийн нийт зардалд эзлэх анхан шатны тусламж, үйлчилгээний зардлын хувь	8	16.0%	23.0%	22.0%	21.8%	–0.9%

Эх үүсвэр: ЭМДЕГ 2021–2024 он

Эрүүл мэндийн даатгалд 2024 оны байдлаар 3,274.9 мянган иргэн даатгуулж, нийт хүн амын эрүүл мэндийн даатгалын хамралт 93.4 хувь болсон нь өмнөх оноос 1.1 хувиар өссөн байна. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлтэй холбоотойгоор даатгалын сангийн орлого 2023 онд өмнөх оноос 3.0 хувиар, сангийн зарлага 12.6 хувиар өссөн бол харин 2024 онд орлого өмнөх оноос 25.9 хувиар, зарлага 19.6 хувиар тус тус өссөн байна. Орлого нэмэгдсэн нь Засгийн газраас нэмэгдүүлж байгаа үндсэн цалингийн нэмэгдэл болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбоотой шимтгэлийн орлогоос шалтгаалж байна.

Хүснэгт 2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчийн тоо (давхардаагүй)

Тусламж, үйлчилгээний төрөл	МД	2021 он	2022 он	2023 он	2024 он	Өөрчлөлтийн хувь
А	Б	1	2	3	4	5=(4–3)/3
Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан иргэний тоо	1	1,783,580	2,011,541	2,671,734	2,815,336	5.4%
Анхан шатны зарим тусламж, үйлчилгээ[1]	2	289,130	360,466	568,744	964,092	69.5%
Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	3	1,413,584	1,738,671	1,973,676	2,069,238	4.8%
Амбулатори	4	1,106,745	1,404,034	1,673,865	1,766,358	5.5%
Өдрийн эмчилгээ	5	25,979	53,512	86,942	112,514	29.4%
Хэвтүүлэн эмчлэх	6	304,128	527,906	543,798	544,935	0.2%
Уламжлалт анагаах ухаан	7	38,870	115,425	188,275	160,395	–14.8%
Сэргээн засах	8	59,479	156,218	183,066	139,784	–23.6%
Түргэн тусламж	9	102673	277,033	303,365	328,405	8.3%
Яаралтай тусламж	10	239422	525,666	591,950	650,717	9.9%
Эмийн үнийн хөнгөлөлт	11	508,837	572,568	645,852	784,869	21.5%
Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг	12	97,166	147,423	357,387	212,382	–40.6%

Эх үүсвэр: ЭМДЕГ 2021–2024 он

2024 оны байдлаар 2.8 сая иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдсан бөгөөд энэ нь Монгол Улсын нийт хүн амын 79.4 хувийг эзэлж байна. Мөн тусламж, үйлчилгээ авсан хүний тоо өнгөрсөн онтой харьцуулахад 5.4 хувиар өсөж тусламж, үйлчилгээний хүртээмж жил бүр нэмэгдэж байна.

1 Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9–д заасан өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ, сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ авсан хүний тоо болно.


Хүснэгт 3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл (сая.төг)

Тусламж, үйлчилгээний төрөл	МД	2021 он	2022 он	2023 он	2024 он	Өөрчлөлтийн хувь
А	Б	1	2	3	4	5=(4–3)/3
Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах (мөр 2+3+14)	1	1,284,644.8	1,455,195.3	1,620,295.3	1,909,590.7	20.0%
Анхан шатын тусламж, үйлчилгээ	2	213,808.9	296,014.2	359,196.8	487,458.8	35.7%
Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ (мөр 4:10)	3	531,599.9	1,032,944.7	1,261,098.5	1,422,131.9	12.8%
Амбулатори	4	106,102.4	175,972.8	279,004.2	328,135.5	17.6%
Өдрийн эмчилгээ	5	33,546.7	61,103.3	82,515.1	95,566.5	15.8%
Хэвтүүлэн эмчлэх	6	316,750.9	622,957.1	696,038.6	805,775.3	15.8%
Уламжлалт анагаах ухаан	7	13,616.5	35,649.4	56,570.0	45,762.2	–19.1%
Сэргээн засах	8	11,340.1	26,689.4	52,600.0	57,953.4	10.2%
Түргэн тусламж	9	16,303.0	24,835.2	28,028.0	32,553.7	16.1%
Яаралтай тусламж	10	33,940.4	85,737.3	66,342.6	56,385.4	–15.0%
Төрөөс төлбөрийг хариуцах эм	11	6,944.5	10,469.3	11,348.3	35,275.9	210.8%
Эмийн үнийн хөнгөлөлт	12	69,417.5	84,251.7	95,684.6	137,801.6	44.0%
Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг	13	4,537.0	16,402.7	42,609.0	31,619.7	–25.8%
Бусад /Ковидын тусламж, үйлчилгээ/	14	539,236.0	126,236.4			
Бүгд /мөр 1+11+12+13/	**15**	**1,365,543.8**	**1,566,319.0**	**1,769,937.2**	**2,114,288.0**	**19.5%**

Эх үүсвэр: ЭМДЕГ 2021–2024 он

2024 оны байдлаар эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд 2,114.3 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өнгөрсөн онтой харьцуулахад 19.5 хувиар нэмэгдсэн байна. Үүнээс лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээнд 1,422.1 тэрбум төгрөгийг зарцуулсан тоонд эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэр төрлөөр авч үзвэл хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд 56.6 хувийг, амбулаторийн тусламж, үйлчилгээнд 23 хувийг, яаралтай тусламжид 3.9 хувь, түргэн тусламжид 2.2 хувь, өдрийн эмчилгээнд 6.7 хувь, сэргээн засах тусламж, үйлчилгээнд 4.0 хувь, уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээнд 3.6 хувийг тус тус зарцуулсан байна.

Зураг 1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд олгосон санхүүжилт, эзлэх хувь



2024 оны байдлаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд олгосон нийт санхүүжилтийг тусламж, үйлчилгээний багцаар нь ангилбал лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардалд 68.9 хувийг, анхан шатны тусламж үйлчилгээнд 23.1 хувийг, урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг тусламж, үйлчилгээнд 1.5 хувийг, эмийн үнийн хөнгөлөлтөд 6.5 хувийг тус тус зарцуулсан байна.

3 ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ТЭНЦЭЛ, ҮР ДҮН

3.1. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХАМРАЛТ.

2024 онд эрүүл мэндийн даатгалд 3,274.9 мянган даатгуулагч хамрагдаж, нийт хамрагдалт 93.5 хувьтай байна. Үүнээс аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагч 770.9 мянга, малчин 51.1 мянга, аж ахуйн нэгж, байгууллагын эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн 117.8 мянга, их, дээд сургууль болон мэргэжлийн сургалт–үйлдвэрлэлийн төвд суралцагч 42.5 мянга, эрүүл мэндийн даатгалыг нь төрөөс хариуцдаг иргэн 2,286.3 мянга, ял эдэлж буй ялтан 4.9 мянга, гадаадын иргэн 1.3 мянган даатгуулагч эрүүл мэндийн даатгалд хамрагдлаа.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3–т заасны дагуу 0–18 насны хүүхэд, тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн–иргэн, хүүхдээ хоёр /ихэр бол гурав/ нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх /эцэг/, хугацаат цэргийн жинхэнэ албан хаагчийн шимтгэлийг улсын төсвөөс төлдөг бөгөөд 2024 оны байдлаар нийт даатгуулагчийн 69.8 хувийг төр даатгалыг нь хариуцах иргэд эзэлж байна.

Зураг 2. Даатгуулагчийн бүтэц, даатгуулагчийн төрөл, хувь, 2024 оны байдлаар



Эрүүл мэндийн даатгалд хамрагдагсдын тоог 2023 онтой харьцуулахад 2024 онд нийт хамралтын хувь 1.1 хувиар өссөн байна. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн тоо 18.0 мянгаар, шимтгэлээ өөрөө хариуцдаг даатгуулагчийн тоо 28.0 мянгаар буурсан бол төр шимтгэлийг хариуцдаг даатгуулагч (0–18 насны хүүхэд, тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн–иргэн, хүүхдээ хоёр /ихэр бол гурав/ нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх /эцэг/)–ийн хамралтын тоо өмнөх оноос нэмэгдсэн байна.

Хүснэгт 4. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчдын тоо

Төрөл	МД	2022 он	2023 он	2024	Харьцуулалт	Өөрчлөлтийн хувь
А	Б	1	2	3	4=3–2	5=4/2
Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7.2 дахь хэсэгт заасан ажилтан	1	749,326	788,986	770,923	–18,063	–2%
Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн;	2	133,921	145,867	117,814	–28,053	–24%
Малчин	3	51,988	57,117	51,187	–5,930	–12%
Гадаадын иргэн, харьяалалгүй хүн	4	567	667	1,306	639	49%
0–18 насны хүүхэд	5	1,312,073	1,329,131	1,353,649	24,518	2%
Тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн	6	561,008	538,558	554,674	16,116	3%
Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн–иргэн	7	268,884	263,645	274,849	11,204	4%
Хүүхдээ хоёр /ихэр бол гурав/ нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх /эцэг/	8	97,033	86,357	97,922	11,565	12%
Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт–үйлдвэрлэлийн төвийн суралцагч	9	14,312	18,815	42,518	4,503	31%
Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч	10	6,809	6,021	5,208	–813	–16%
Ял эдэлж байгаа ялтан	11	4,581	5,055	4,908	–147	–3%
Нийт даатгуулагчийн тоо (Мөр 1:11)		**3,200,502**	**3,240,219**	**3,274,958**	**34,739**	**1%**

Эх үүсвэр: ЭМДЕГ 2022–2024 он

Албан бус салбарын ажилчид болох хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчид, оюутнуудын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь жил бүр хамгийн бага байгаа бөгөөд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгцээ шаардлага үүссэн тохиолдолд нөхөн төлөх хандлагатай байна.

Хүснэгт 5. Эрүүл мэндийн даатгалд хамгийн бага хамрагдсан бүлэг

Он	Малчдын хамралт	Оюутны хамралт
2020	59.7%	19.9%
2021	39.4%	10.7%
2022	39.9%	11.6%
2023	44.8%	15.2%
2024	36,0%	72.0%

Эх үүсвэр: ЭМДЕГ 2022–2024 он

Монгол Улсад дунджаар 300 орчим малчин, 150 орчим мянган оюутан статистикт бүртгэгдсэн бөгөөд хүүхэд, тэтгэврийн болон эмзэг бүлгийн малчдыг оруулахгүйгээр тооцоолж үзэхэд 130 орчим мянган малчид шимтгэл төлөх ёстой боловч хамралтын түвшин нь дунджаар 36.7 хувь байна. Малчдыг шимтгэл төлүүлэх үүргийг сум, дүүргийн Засаг дарга хариуцдаг. Харин 19 нас хүртэлх оюутнуудын шимтгэлийг улсын төсвөөс төлдөг бөгөөд 19 наснаас дээш оюутан шимтгэлээ өөрөө хариуцаж төлдөг. Шимтгэл төлүүлэх үүргийг их, дээд сургууль, коллеж хариуцдаг бөгөөд сүүлийн 5 жилийн хамралтын хувь нь дунджаар 25.8 хувь байна. Гэвч зарим оюутан давхар ажил хөдөлмөр эрхэлдэг бөгөөд гэрээт болон хөлсөөр ажилласан тохиолдолд аж ахуй нэгж нь ЭМД, нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тооцдог. Энэ нь зарим талаараа давхардал болдог байсан ба 2020 оноос давхар төлсөн шимтгэл төлөлтийн давхардлыг арилгаж цэвэрлэж бүртгэдэг болсон.

Хүснэгт 6. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ QR –уншуулах /Хавсралт–5/

3.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО.

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого нь 1) даатгуулагчийн төлөх шимтгэлийн орлого, 2) төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс олгосон санхүүжилтийн орлого, 3) бусад орлогоос бүрддэг бөгөөд 2024 онд санд нийт 2,025.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсний 57.9 хувь буюу 1,170.9 тэрбум төгрөгийг даатгуулагчийн төлсөн шимтгэлээс, 36.8 хувь буюу 746,8 тэрбум төгрөгийг төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс олгосон санхүүжилтээс, 5.3 хувь буюу 108.0 тэрбум төгрөгийг бусад орлогоос тус тус бүрдүүлсэн байна. 2024 оны байдлаар төлөвлөсөн орлогын гүйцэтгэл 103.1 хувь байгаа нь Эрүүл мэндийн сайдын багц болон олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд нэмэлт санхүүжилт татан төвлөрүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулсантай холбоотой юм.

Хүснэгт 7. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын гүйцэтгэл (сая.төг.)

Төрөл	МД	2022 оны гүйцэтгэл	2023 оны гүйцэтгэл	2024 он			Өөрчлөлтийн хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь	
А	Б	1	2	3	4	5=4/3	6=(4–2)/2
Ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл	1	492,916.1	618,182.8	859,154.8	812,662.2	94.6%	31.5%

Төрөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл	2	163,708.7	252,061.1	324,113.0	324,113.0	100.0%	28.6%
Бусад даатгуулагчийн төлөх шимтгэл	3	25,171.1	29,141.4	34,684.8	34,199.5	98.6%	17.4%
Төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	4	540,429.9	687,445.3	746,804.8	746,804.8	100.0%	8.6%
Бусад орлого	5	337,787.6	21,884.3		108,046.9		393.7%
Нийт орлогын дүн (мөр 1:5)	**6**	**1,560,013.4**	**1,608,714.9**	**1,964,757.4**	**2,025,826.3**	**103.1%**	**25.9%**

Эх үүсвэр: ЭМДЕГ 2022–2024 он

3.2.1 Даатгуулагчийн шимтгэлийн орлого.

Даатгуулагчийн төлөх шимтгэлийн орлогыг 2023 онтой харьцуулахад 271,5 тэрбум төгрөгөөр буюу 30.2 хувиар өссөн байна. Хэдийгээр тус онд даатгуулагчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт ороогүй боловч энэхүү өсөлт нь цалингийн болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өсөлттэй шууд холбоотой юм. 2024 оны байдлаар даатгуулагчийн төлөх шимтгэлийн орлогын 69.4 хувийг ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл, 27.7 хувийг төр хариуцах иргэдийн шимтгэл, 2.9 хувийг шимтгэлээ өөрөө хариуцан төлж байгаа даатгуулагчийн орлого тус тус эзэлж байна.

Хүснэгт.8. Даатгуулагчийн төлсөн шимтгэлийн орлого, даатгуулагчийн төрлөөр (сая.төг)

Төрөл	МД	2022 оны гүйцэтгэл	2023 оны гүйцэтгэл	2024 он			Өөрчлөлт хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
А	Б	1	2	3	4	5=4/3	6=(4–2)/2
Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7.2 дахь хэсэгт заасан ажилтан **(Мөр 2+3)**	**1**	**492,916.1**	**618,182.8**	**859,154.8**	**812,662.2**	**94.6%**	**31.5%**
Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогчийн төлөх шимтгэл	**2**	276,817.2	301,055.4	412,394.3	389,265.2	94.4%	29.3%
Даатгуулагчийн төлөх шимтгэл	**3**	216,098.9	317,127.4	446,760.5	423,397.0	94.8%	33.5%
Төр шимтгэлийг нь хариуцах иргэдийн шимтгэл (мөр 5:10)	**4**	**163,708.7**	**252,061.2**	**324,113.0**	**324,113.0**	**100%**	**28.6%**
0–18 насны хүүхэд	**5**	66,129.1	107,036.6	137,702.4	137,702.4	100%	28.6%
Тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн	**6**	56,550.9	86,741.5	111,592.8	111,592.8	100%	28.6%

Хүүхдээ 2 /ихэр бол 3/ нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх /эцэг/	**7**	9,781.2	13,908.9	17,893.7	17,893.7	100%	28.6%
Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан иргэн[1]	**8**	30,099.5	42,463.3	54,629.0	54,629.0	100%	28.6%
Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч	**9**	686.0	1,096.7	1,247.6	1,247.6	100%	13.8%
Ял эдэлж байгаа ялтан	**10**	462.0	814.2	1,047.4	1,047.4	100%	28.6%
Бусад даатгуулагчийн төлөх шимтгэл (мөр 12:15)	**11**	**25,171.1**	**29,141.0**	**34,684.8**	**34,199.5**	**98.6%**	**17.4%**
Малчин	**12**	6,517.3	7,143.7	10,596.2	10,448.0	98.6%	46.3%
Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт–үйлдвэрлэлийн төвийн суралцагч	**13**	1,794.2	1,520.1	4,471.3	4,408.8	98.6%	190.0%
Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн	**14**	16,788.5	20,389.2	19,574.1	19,300.0	98.6%	–5.3%
Гадаадын иргэн, харьяалалгүй хүн	**15**	71.1	88.0	43.2	42.7	98.8%	–51.5%
Шимтгэлийн орлогын дүн (Мөр 1+4+11)	**16**	**681,795.9**	**899,385.0**	**1,217,952.6**	**1,170,974.7**	**96.1%**	**30.2%**

Эх үүсвэр: ЭМДЕГ 2022–2024 он

3.2.2 Төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс олгосон санхүүжилтийн орлого.

Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6–д заасны дагуу дараах эмнэлгийн тусламж, үйлчилгээний төлбөрийг төр хариуцах зохицуулалттай байдаг. Үүнд:

- жирэмсэн, төрөлт, төрсний дараах үетэй холбоотой эх барихын тусламж, үйлчилгээний зардал;
- төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас хүүхдэд үзүүлэх эмнэлгийн зарим тусламж, үйлчилгээ;
- аргагүй хамгаалалт, гарцаагүй байдалд хүний амь нас аврахаар яваад гэмтсэн, өвчилсөн хүний эмчилгээ;
- сүрьеэ, хорт хавдар, сэтгэцийн эмгэгийн зарим эмчилгээ;
- удаан хугацааны нөхөх эмчилгээ шаардах эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний зарим эмийн зардал;
- эмнэлгийн яаралтай болон түргэн тусламж, халдварт өвчний оношилгоо, эмчилгээ, бие махбодийн ба бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогчид үзүүлэх эрүүл мэндийн болон сэтгэцийн сэргээн засах тусламж, үйлчилгээ:
- өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх зарим тусламж, үйлчилгээ зэрэг болно.

Дээрх тусламж, үйлчилгээний санхүүжилтийг Эрүүл мэндийн сайдын багцын төсвөөс Эрүүл мэндийн даатгалын сан руу сар бүр улсын төсвийн татаас санхүүжилтийг төвлөрүүлж байна. 2024 онд нийт 746,8 тэрбум төгрөгийг санд төвлөрүүлсэн бол эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлсэн төр хариуцах тусламж, үйлчилгээний бодит гүйцэтгэл 936,4 тэрбум төгрөг буюу 25 хувийн хэтрэлттэй байна. Төр хариуцах тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийн 46.2 хувийг анхан шатны тусламж, үйлчилгээ, 53.8 хувийг лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ тус тус эзэлж байна. Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний 53.6 хувийг хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ, 7.7 хувийг гемодиализийн тусламж, 11.2 хувийг яаралтай тусламж, 6.5 хувийг түргэн тусламж, 9.2 хувийг амбулаторийн тусламж, үйлчилгээ, 4.8 хувийг өдрийн эмчилгээ, 7 хувийг төлбөрийг төр хариуцах эм тус тус эзэлж байна.

Хүснэгт 9. Төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс олгох хөрөнгө (сая.төг)

Төрөл	МД	2022 оны гүйцэтгэл	2023 оны гүйцэтгэл	2024 он			Өөрчлөлт хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
А	Б	1	2	3	4	5=4/2	6=(4–2)/2
Тухайн жилд улсын төсвөөс олгосон татаас санхүүжилт	1	540,429.9	687,445.3	746,804.8	746,804.8	100%	8.6%
Төр хариуцах тусламж, үйлчилгээний бодит гүйцэтгэл (мөр 3:12)	**2**	**765,398.1**	**817,442.4**	**837,652.6**	**936,471.7**	**125%**	**14.6%**
Амбулаторийн тусламж, үйлчилгээ	3	11,574.1	36,137.2	28,941.9	38,002.1	131.3%	5.2%
Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ	4	5,430.5	12,285.8	2,712.7	8,277.9	305.1%	–32.6%
Диализын тусламж, үйлчилгээ	5	26,298.5	31,466.1	37,466.1	38,703.0	103.3%	23.0%
Өдрийн эмчилгээ	6	22,597.7	30,239.2	20,060.7	24,771.2	123.5%	–18.1%
Түргэн тусламж, үйлчилгээ	7	24,835.2	28,028.0	30,442.1	32,553.7	106.9%	16.1%
Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	8	157,404.2	242,398.3	194,839.1	270,066.4	138.6%	11.4%
Яаралтай тусламж, үйлчилгээ	9	85,737.3	66,342.6	71,751.9	56,385.4	78.6%	–15.0%
Анхан шатны тусламж, үйлчилгээ	10	296,014.2	359,196.8	425,060.9	432,436.2	101.7%	20.4%
Ковид–19	11	126,236.4					
Төр хариуцах эм	12	9,269.9	11,348.3	26,377.0	35,275.9	133.7%	210.8%

Эх үүсвэр: ЭМДЕГ 2022–2024 он

3.2.3 Бусад орлого.

Бусад орлого хэсэгт дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан нэмэлт орлого, сангийн хөрөнгийг зохих журмын дагуу хадгалуулсан, түрээсэлсэн, худалдан борлуулсан зэрэг үндсэн бус бусад төрлийн орлогыг хамруулан тайлагнадаг.

Хүснэгт 10. Бусад орлого, төрлөөр (сая.төг)

Төрөл	МД	2023 оны гүйцэтгэл	2023 оны гүйцэтгэл	2024 оны гүйцэтгэл	Харьцуулалт зөрүү
А	Б	1	2	3	4=(3–2)
Өмнө оны өр төлбөр барагдуулах нэмэх санхүүжилт	1	295,335.10	20,000.00	104,082.90	84,082.90
Бусад орлого	2	42,452.50	1,884.30	3,964.00	2,079.70
Бусад орлогын дүн	**3**	**337,787.60**	**21,884.30**	**108,046.90**	**86,162.60**

Эх үүсвэр: Санхүүгийн аудитын тайлан

2024 онд Эрүүл мэндийн сайдын багцын улсын төсвөөс 35 тэрбум төгрөг, Азийн хөгжлийн банкны “Ковид–19” цар тахлын эсрэг вакцинжуулалтын арга хэмжээг дэмжих төслийн “Апвакс хөтөлбөр”–ийн санхүүжилтээс 69.0 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилтийг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хуваарилсантай холбоотойгоор бусад орлого өссөн байна.

Хүснэгт 11. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12.1.1–д заасны дагуу нөхөн төлбөрийн дүн, оноор[2] (сая.төг)

Огноо	МД	Хүний тоо	Мөнгөн дүн
А	Б	1	2
2022 он	1	610	281.2
2023 он	2	2,025	1,202.6
2024 он	3	3,421	2,406.8
Нийт (мөр 1+2+3)	**3**	**6,056**	**3,890.6**

Эх үүсвэр: Санхүүгийн аудитын тайлан

Гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрүүл мэнд нь хохирсон даатгуулагчийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг холбогдох хууль хяналтын байгууллага хариуцан бууруулах этгээдээр нөхөн төлүүлдэг бөгөөд энэ асуудлаар Прокурорын байгууллагатай хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд эрүүл мэндийн даатгалын санд 2023 онд 1,202.6.сая төгрөгийг нөхөн төлүүлсэн бол 2024 онд 2 дахин нэмэгдүүлсэн дүнгээр нөхөн төлүүлсэн.

2 Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1. дэх хэсэг “Дараах зардлыг доор дурдсан этгээдээр нөхөн төлүүлнэ;12.1.1–д заасан дагуу гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрүүл мэнд нь хохирсон даатгуулагчийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг холбогдох хууль хяналтын байгууллага хариуцан бууруулах этгээдээр эрүүл мэндийн даатгалын байгууллагад”

3.3. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагыг 2024 онд 1,933.1 тэрбум төгрөгөөр баталсан бөгөөд эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлсэн тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийн тоо хэмжээ жил бүр тасралтгүй өсөж байгаатай холбоотойгоор зарлагын гүйцэтгэл 2,129.3 тэрбум төгрөг болж, 10.1 хувиар хэтэрсэн байна. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийг жил бүр үе шаттайгаар нэмэгдүүлж байгаа боловч төсвөөс давсан тусламж, үйлчилгээний нэхэмжлэл ирж байгаа нь хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгцээ, өвчлөл их байгааг харуулж байна.

Хүснэгт 12. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын тойм (сая.төг)

Төрөл	МД	2022 оны гүйцэтгэл	2023 оны гүйцэтгэл	2024 он			Өөрчлөлтийн хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл хувь	
А	Б	1	2	3	4	5=4/3	6=(4–2)/2
Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал	1	1,565,472.1	1,769,937.2	1,862,692.3	2,114,288.0	113.5%	19.5%
Үйл ажиллагааны урсгал зардал	2	14,381.6	10,285.8	16,445.8	15,049.5	91.5%	46.3%
Эрсдэлийн сан	4			53,562.6		0.0%	
Бусад	5	348.5	313.9	470.9	25.6	5.4%	–91.9%
Нийт зарлагын дүн (мөр 1:5)	**6**	**1,580,202.2**	**1,780,537.0**	**1,933,171.6**	**2,129,363.0**	**110.1%**	**19.6%**

Эх үүсвэр: ЭМДЕГ 2022–2024 он

3.3.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал.

2024 онд эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын 99.3 хувийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд, 0.7 хувь нь эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд зарцуулагдсан байна. Харин эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нийт зардлын 67.3 хувь нь лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээнд, 23.1 хувь нь анхан шатны тусламж, үйлчилгээнд, 8.2 хувь нь төр хариуцах болон эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд, 2.5 хувь нь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үйлчилгээнд тус тус зарцуулагдсан байна.

Хүснэгт 13. Эрүүл мэндийн даатгалын сангийн зардлын гүйцэтгэл (сая.төг)

Төрөл	МД	2022 оны гүйцэтгэл	2023 оны гүйцэтгэл	2024 он			Өөрчлөлт хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл хувь	
А	Б	1	2	3	4	5=4/3	6=(4–2)/2
Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ (мөр 2:12)	1	1,032,944.7	1,261,098.5	1,242,090.5	1,422,131.9	114.5%	12.8%
Амбулаторийн тусламж, үйлчилгээ	2	146,474.0	226,919.3	239,674.3	300,052.3	125.2%	32.2%
Өдрийн эмчилгээ	3	47,908.4	82,515.1	84,824.7	95,566.5	112.7%	15.8%
Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ	4	13,194.9	52,046.1	6,878.8	28,044.7	407.7%	–46.1%
Сувиллын тусламж, үйлчилгээ	5	29,469.5		29,686.1	21,254.8	71.6%	
Сэргээн засах тусламж, үйлчилгээ	6	26,689.4	52,600.0	31,182.2	36,698.6	117.7%	–30.2%
Телемедициний тусламж, үйлчилгээ	7	29.3	38.8	41.0	38.4	93.7%	–0.9%
Түргэн тусламж	8	24,835.2	28,028.0	30,442.1	32,553.7	106.9%	16.1%
Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ	9	35,649.4	56,570.0	35,260.7	45,762.2	129.8%	–19.1%
Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ	10	4,931.2	6,994.7	7,734.8	8,487.4	109.7%	21.3%
Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	11	618,026.0	689,043.8	704,613.8	797,287.9	113.2%	15.7%
Яаралтай тусламж	12	85,737.3	66,342.6	71,751.9	56,385.4	78.6%	–15.0%
Анхан шатны тусламж, үйлчилгээ	13	296,014.2	359,196.8	425,060.9	487,458.8	114.7%	35.7%
Төр хариуцах эм	14	9,269.9	11,348.3	26,377.0	35,275.9	133.7%	210.8%
Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг	15	16,402.7	42,609.0	31,841.1	31,619.7	99.3%	–25.8%
Эмийн үнийн хөнгөлөлт	16	84,251.7	95,684.6	137,322.8	137,801.6	100.3%	44.0%
Элэг бүтэн монгол хөтөлбөр	17	352.4					
Ковидын тусламж, үйлчилгээ	18	126,236.4					
Нийт дүн (мөр 1+13+14+15+16+17+18)	**19**	**1,565,472.0**	**1,769,937.2**	**1,862,692.3**	**2,114,288.0**	**113.5%**	**19.5%**

Эх үүсвэр: ЭМДЕГ 2022–2024 он

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл төлөвлөсөн зарлагаас 13.5 хувиар хэтэрсэн. Бүтцийг нь авч үзвэл лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний гүйцэтгэл 14.5 хувиар, анхан шатны тусламж, үйлчилгээний гүйцэтгэл 14.7 хувиар, төр хариуцах эмийн гүйцэтгэл 33.7 хувиар тус тус хэтэрсэн байна. 2024 онд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор зарим тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, төлбөрийн аргад бодлогын тохируулга хийсэнтэй холбоотойгоор тусламж, үйлчилгээний тоо хэмжээ өсөж буурсан байна. Тухайлбал амбулаторийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээг эмчийн үзлэгтэй хамтад нь цогц, уялдаатай хөгжүүлэх замаар дахин багцалсан, мөн архаг өвчлөлийн хэвтэлтийг бууруулж өдрийн эмчилгээгээр амбулаториар хянахыг дэмжиж, цочмог үеийн сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх, хорт хавдрын тусламж, үйлчилгээг химийн бай эмчилгээний эмийг тусад нь санхүүжүүлэх зэрэг өөрчлөлтийн үр дүнд тусламж, үйлчилгээний тоо хэмжээнд өөрчлөлт орсон байна.

Зураг 3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нийт зардалд эзлэх хувь



2024 оны байдлаар эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл нийт 2,114.3 тэрбум төгрөг гарсан бөгөөд эрүүл мэндийн байгууллагын төрлөөр нийт зардалд эзлэх хувийг авч үзвэл улсын эмнэлэгт 52.2 хувь, хувийн эмнэлэгт 13.8 хувь, сувилалд 1.3 хувь, анхан шатны тусламж үйлчилгээнд нийт зардлын 23 хувь, үүнээс нэг иргэний санхүүжилт 16.3 хувь, өрх, сум тосгоны ЭМТ–өөс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд 6.7 хувь, эмийн санд 6.5 хувь, урьдчилан сэргийлэх үзлэгт 1.5 хувь, төр хариуцах эмийн зардалд 1.7 хувийг тус тус зарцуулсан байна.

Нэг даатгуулагчид ногдох эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний дундаж зардал 2024 оны байдлаар 406.7 мянган төгрөг, хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний дундаж зардал хамгийн өндөр буюу 1,464.6 мянган төгрөг, амбулаторийн тусламж, үйлчилгээний дундаж зардал хамгийн бага буюу 168.5 мянган төгрөг байна.

Хүснэгт 14. Нэг даатгуулагчид ногдох эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний дундаж зардал, насны бүлгээр, 2024 он(мян.төг)

Насны ангилал	МД	Нийт даатгуулагчийн тоо	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг	Анхан шат	Хэвтүүлэн эмчлэх	Амбулатори	Яаралтай, түргэн тусламж	Өдрийн эмчилгээ	Уламжлалт, сэргэн засах	Эмийн үнийн хөнгөлөлт	Дундаж
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10
0–4	1	312,596		53.0	1071.0	112.9	88.8	278.9	154.6	17.5	214.5
5–9	2	383,241	*[1]	21.2	865.5	111.5	69.5	322.3	205.5	29.5	113.1
10–14	3	366,994		15.9	942.0	107.5	72.7	344.4	195.5	52.3	112.5
15–19	4	315,349	85.6	25.1	1113.6	121.6	81.9	413.5	187.9	70.7	153.5
20–24	5	182,313	81.6	53.5	1171.0	155.2	89.9	543.5	172.3	66.3	231.7
25–29	6	199,197	83.4	63.8	1150.4	178.7	91.6	500.6	179.4	83.7	253.8
30–34	7	227,291	139.2	65.7	1214.4	180.1	90.6	557.9	194.4	89.4	260.5
35–39	8	253,294	158.9	67.5	1334.0	182.3	91.3	648.0	199.4	103.8	271.7
40–44	9	204,807	158.4	74.5	1490.5	183.0	92.6	737.8	220.7	125.8	285.1
45–49	10	178,564	167.2	80.8	1647.9	190.0	94.5	968.2	236.2	151.9	312.7
50–54	11	160,080	173.0	87.9	1708.4	204.8	95.2	1108.1	260.3	182.9	339.0
55–59	12	146,362	172.2	94.6	1863.5	215.7	99.5	1102.1	312.4	209.7	373.0
60–64	13	146,258	160.9	102.5	1958.2	227.0	101.2	1239.0	345.4	233.6	406.9
65–дээш нас	14	195,797	152.8	126.5	2036.3	236.8	136.3	1363.9	390.6	285.2	460.2
Дундаж (мөр 1:14)	**15**	**3,272,144**	**148.9**	**56.6**	**1464.6**	**168.5**	**90.9**	**850.4**	**274.9**	**171.5**	**406.7**

Эх үүсвэр: ЭМДЕГ 2024 он

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдаж байгаа байршлаар нь авч үзэхэд Улаанбаатар хотод байршилтай эрүүл мэндийн байгууллагуудад нийт тусламж, үйлчилгээний тохиолдлын 56.8 хувь нь үйлчлүүлсэн байгаа гол лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээнд 63.2 хувь нь хамрагдсан байна.

Хүснэгт 15. Эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээний төрөл, эзлэх хувь оноор

Тусламж, үйлчилгээний төрөл	Мөр	2022 он		2023 он		2024 он	
		Аймаг	УБ	Аймаг	УБ	Аймаг	УБ
А	Б	1	2	3	4	5	6
Анхан шатны тусламж, үйлчилгээ	1	52.0%	48.0%	48.3%	51.7%	49.4%	50.6%
Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ	2	37.2%	62.8%	36.3%	63.7%	36.8%	63.2%
Эмийн үнийн хөнгөлөлт	3	45.7%	54.3%	43.1%	56.9%	44.1%	55.9%
Эрт илрүүлгийн тусламж, үйлчилгээ	4	33.5%	66.5%	35.9%	64.1%	39.4%	60.6%
Нийт дүнд эзлэх хувь	**5**	**42.4%**	**57.6%**	**41.9%**	**58.1%**	**43.2%**	**56.8%**

Эх үүсвэр: ЭМДЕГ 2022–2024 он

3.3.2 Үйл ажиллагааны урсгал зардал.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлыг эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн орлогын 5 хувиас илүүгүй байхаар хуульчилсан байдаг бөгөөд 2024 оны байдлаар үйл ажиллагааны зардалд 0.7 хувийг зарцуулсан байна.

Хүснэгт 16. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл, оноор (сая.төг)

Код	Эдийн засгийн ангилал	МД	2022 он	2023 он	2024он	Өөрчлөлтийн хувь
А	Б	В	1	2	3	4=(3–2)/2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1	4,466.30	6,189.80	8,210.2	33%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2	569.9	781.8	1,030.6	32%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3	171.9	167.1	140.8	–16%
2104	Хангамж, бараа материалын зардал	4	217..44	227.1	206.7	–9%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5	180.3	67.4	383.5	469%
2107	Томилолт, зочны зардал	6	111.4	116.4	127.5	10%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7	7,180.20	2,313.50	7,340.7	217%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8	201.5	168	783.8	367%
2132	Татаас	9	160.5	254.7	278.2	9%
	Нийт зарлагын дүн (мөр 1:9)	**10**	**13,042.00**	**10,285.80**	**14,650.1**	**42%**

Эх үүсвэр: Санхүүгийн аудитын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан

3.3.3 Эрсдэлийн сангийн зардал.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулиар эрсдэлийн сангийн хөрөнгийг 53.5 тэрбум төгрөгөөр баталсан. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өвчлөлийн өсөлтөөс шалтгаалж зарлагын гүйцэтгэл нь батлагдсан төсвөөс давж, эрүүл мэндийн байгууллагад санхүүжилт олгох боломжгүй болсон. Иймд Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 28–ны өдрийн “Эрүүл мэндийн даатгалын 2024 оны эрсдэлийн сангийн хөрөнгийг зарцуулах тухай” 16 дугаар тогтоолын дагуу эрсдэлийн сангийн хөрөнгийг лавлагаа шатлалын эрүүл мэндийн үндсэн тусламж, үйлчилгээнд (амбулатори, хэвтүүлэн эмчлэх) зарцуулсан.

Хүснэгт 17. Эрсдэлийн сангийн гүйцэтгэл, зориулалт (сая.төг)

Зориулалт	МД	2022 он	2023 он	2024 он
А	Б	1	2	3
Орлогын тасралт	1			
Өвчлөлийн өсөлт	2	40,000.00	40,000.00	53,562.60

Үнийн өсөлт	3			
Гамшиг /Ковид/	4			
Бусад	5			
Нийт зарлагын дүн (мөр 1:6)	**6**	**40,000.00**	**40,000.00**	**53,562.60**

Эх үүсвэр: Санхүүгийн аудитын тайлан

3.4.Эрүүл мэндийн даатгалын сангийн тэнцэл.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулиар сангийн орлогыг 1,964.7 тэрбум төгрөгөөр батлсан бөгөөд гүйцэтгэл нь 1,921.7 тэрбум төгрөг байгаа ба ажил олгогч, даатгуулагчаас төвлөрөх орлого 46.4 тэрбум төгрөгөөр тасраад байна.

Харин сангийн зарлагыг 1,933.1 тэрбум төгрөгөөр батлсан бөгөөд гүйцэтгэл нь 2,129.3 тэрбум төгрөг гарсан ба үүнээс нэмэлт санхүүжилтээр 104 тэрбум төгрөгийн зарлагыг санхүүжүүлсэн.

Хүснэгт 18. Эрүүл мэндийн даатгалын сангийн тэнцэл (сая.төг)

Төрөл	МД	2022 он	2023 он	2024 он
А	Б	1	2	3
Үйл ажиллагааны орлогын дүн	1	1,514,581.3	1,584,963.4	1,921,743.4
Үйл ажиллагааны зардлын дүн	2	1,569,178.4	1,780,537.0	2,129,363.0
Ашиг, алдагдал (мөр 2–1)	**3**	**– 54,597.1**	**– 195,573.6**	**– 207,619.6**
Авлага	4	106,206.8	79,731.5	168,798.7
Өглөг	5	60,591.9	218,321.7	316,851.4
Дансны үлдэгдэл	6	170,366.0	161,057.1	146,271.5

Эх үүсвэр: Санхүүгийн аудитын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 2024 оны жилийн эцэст 146.2 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 14.7 тэрбум төгрөгөөр буурсан байна. Мөнгөн хөрөнгө буурсан шалтгаан нь Улсын их хурлаас батлагдсан Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулиар төвлөрүүлэхээр тооцсон ажил олгогч, даатгуулагчаас төлөх орлого биелээгүй бөгөөд дансны үлдэгдлээс орлогын дутагдлыг санхүүжүүлсэн.

Авлага дансны эцсийн үлдэгдэл 168.7 тэрбум төгрөг болж өмнөх оноос 89 тэрбум төгрөгөөр өссөн. Авлага өссөн шалтгаан нь Нийгмийн даатгалын байгууллагаас эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлдэг ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн орлогын гүйцэтгэлд аудит хийгдэж 89 тэрбум төгрөгийн санхүүжилтийг дутуу төвлөрүүлсэн байсныг илрүүлж авлагаар тусгаж тайлагнасан.

Сүүлийн 3 жилийн хуримтлагдсан өр төлбөрийн нийт дүн 316.8 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд 2024 онд өр төлбөр 98,5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

4 ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ХУДАЛДАН АВЧ БАЙГАА ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР

4.1.АНХАН ШАТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ.

Анхан шатны тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх асуудлыг ЭМДҮЗ–ийн 2021 оны 04 дүгээр, 2022 оны 05 дугаар, 2023 оны 06 дугаар, 2024 оны 05 дугаар тогтоолуудаар тус тус журамлаж, хэрэгжүүлж байна. Эдгээр тогтоолын хэрэгжилтийн явцад үүсэж буй тулгамдсан асуудал (цахим системийн хөгжүүлэлт, тусламж, үйлчилгээний жагсаалтыг шинэчлэх, цөөн хүн амтай зарим тосгон, сумдын эрүүл мэндийн төвийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл хангалтгүй гарсан, хөдөө орон нутгийн нэмэгдэл г.м)–ыг шийдвэрлэх талаар холбогдох журамд өөрчлөлт, оруулахаар ажиллаж байна.

2024 оны хувьд ЭМДҮЗ–ийн 05 дугаар тогтоолд Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21–ний өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолын дагуу 2024 оны 04 дүгээр сарын 01–ний өдрөөс үндсэн цалинг нэмэгдүүлсэнтэй, мөн орон нутгийн нэмэгдэл хөлс олгож эхлэхтэй холбоотойгоор төсвийг анхан шатны болон эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийн индекст тусгаж, бодлогын тохируулга хийж хэрэгжүүлээд байна.

Анхан шатны тусламж, үйлчилгээний багцын зорилго нь харьяаллын хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгцээг хангаж, хүн амаа эрүүл байлгах, эрүүл мэндийг хянах, хэрэв өвчилсөн тохиолдолд анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлэх, шаардлагатай тохиолдолд лавлагаа шатлалд илгээх явдал бөгөөд анхан шатны тусламж, үйлчилгээнд зарцуулах төсвийг жил бүр үе шаттайгаар нэмэгдүүлэх бодлогыг баримталж ажиллана. 2022 онд 538 анхан шатны эрүүл мэндийн байгууллагад 296 тэрбум төгрөг, 2023 онд 545 анхан шатны эрүүл мэндийн байгууллагад 359,1 тэрбум төгрөг, 2024 онд 552 анхан шатны эрүүл мэндийн байгууллагад 487,4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна.

Хүснэгт 19. Анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт, эрүүл мэндийн байгууллагын төрлөөр (сая.төг)

Эрүл мэндийн байгууллагын төрөл	МД	2022 он		2023 он		2024 он	
		ЭМБ–ын тоо	Олгохоор тооцсон санхүүжилт[3]	ЭМБ–ын тоо	Олгохоор тооцсон санхүүжилт	ЭМБ–ын тоо	Олгохоор тооцсон санхүүжилт
А	Б	1	2	3	4	5	6
Өрхийн эрүүл мэндийн төв	1	210	107,194.7	217	142,026.0	224	159,312.0
Сум, тосгоны эрүүл мэндийн төв	2	328	188,819.5	328	217,170.8	328	328,146.8
Нийт анхан шатны тусламж, үйлчилгээний зардал (мөр 1:2)	**3**	**538**	**296,014.2**	**545**	**359,196.8**	**552**	**487,458.8**

Эх үүсвэр: ЭМДЕГ 2022–2024 он

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд заасны дагуу анхан шатны суурь тусламж, үйлчилгээг нэг иргэнээр тооцсон төлбөрийн хэлбэрээр, зарим төрлийн оношилгоо, шинжилгээ, өдрийн эмчилгээ, сэргээн засах болон, гэрийн тусламж, үйлчилгээг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар, мөн сум, тосгоны эрүүл мэндийн төвөөр үзүүлдэг хэвтүүлэн эмчлэх, яаралтай, түргэн тусламж болон, шүдний тусламж, үйлчилгээг лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлж байгаа оношийн хамааралтай бүлгийн санхүүжилтийн аргаар тус тус санхүүжүүлж байна.

2024 онд 487.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд олгосон бөгөөд 2023 оноос 36 хувиар өссөн байна. Нийт санхүүжилтийн 70.9 хувийг нэг иргэнээр тооцсон санхүүжилт, 17.8 хувийг сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилт, 11.3 хувийг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээний санхүүжилт тус тус эзэлж байна. Нэг иргэнээр тооцсон санхүүжилтэд 345.5 тэрбум төгрөгийг олгосон ба өмнөх оноос 26 хувиар санхүүжилт нэмэгдсэн байгаа нь Монгол Улсын Засгийн газраас төрийн албан хаагчийн цалин, хөлсийг нэмэгдүүлэх шийдвэр гарсантай холбоотой байна.

Хүснэгт 20. Анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл (сая.төг)

Анхан шатны тусламж, үйлчилгээ	МД	2022 он	2023 он	2024 он	Өөрчлөлтийн хувь
А	Б	1	2	3	4=(3–2)/1
Нэг иргэнээр тооцсон тусламж, үйлчилгээ	1	197,498.2	274,924.4	345,502.5	26%
СТЭМТ–с үзүүлэх тусламж, үйлчилгээ	2	38,023.6	50,290.9	86,933.7	73%
ӨСТЭМТ–өөс үзүүлэх тусламж, үйлчилгээ	3	14,334.0	34,083.7	55,022.6	61%
Нийт анхан шатны тусламж, үйлчилгээний зардал	**4**	**296,014.2**	**359,196.8**	**487,458.8**	**36%**

Эх үүсвэр: ЭМДЕГ 2022–2024 он

3 “Олгохоор тооцсон санхүүжилт” гэж ЭМД–ын байгууллагын тухайн эрүүл мэндийн байгууллагын нэхэмжлэлийг гэрээний дагуу хүлээн авч хянаж санхүүжүүлэхээр хүлээн зөвшөөрсөн мөнгөн дүнг хэлнэ.


Анхан шатны тусламж, үйлчилгээний санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлтийг ЭМДҮЗ–ийн тогтоолоор батлуулж, сар бүр нэг иргэнээр тооцсон санхүүжилтээс урьдчилгаа 80 хувийг олгон, гэрээний шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинд хүрсэн тохиолдолд нийт санхүүжилтийн үлдэгдэл 20 хувийг олгон ажиллаж байна. 2024 оны байдлаар урьдчилгаа санхүүжилтэд 315.1 тэрбум төгрөг, гүйцэтгэлийн урамшуулалд 30.3 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Хүснэгт 21. Нэг иргэнээр тооцсон тусламж, үйлчилгээний гүйцэтгэл (сая.төг)

Анхан шатны тусламж, үйлчилгээ	МД	2022 он	2023 он	2024 он	Өөрчлөлтийн хувь
А	Б	1	2	3	4=(3–2)/1
Нэг иргэнээр тооцсон санхүүжилт (мөр 2:3)	1	197,498.20	274,924.40	345,502.50	26%
Урьдчилгаа 80 хувь	2	160,886.20	237,313.60	315,166.20	33%
Гүйцэтгэлийн урамшуулал 20 хувь	3	36,612.00	37,610.80	30,336.30	–19%

Нэг иргэнээр тооцсон тусламж, үйлчилгээний хувьд анхан шатны ЭМБ–ууд нь жил бүр харьяалах хүн амынхаа эрүүл мэндийн байдлыг тогтмол үнэлэх, халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг товлолт насанд нь хийх, шаардлагатай тохиолдолд шатлалын тусламжид илгээх, анхан шатны эрүүл мэндийн байгууллагын тогтмол хяналтад байх шаардлагатай халдварт болон халдварт бус өвчин, жирэмсэн, төрөх, нярай, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийг хянах, дэмжих, товлолын болон нэмэлт дархлаажуулалтад хамруулах, асрах, сувилах сэргээн засах, эмчлэх (ӨЭМТ–д өдрөөр, СЭМТ–д өдрөөр болон хэвтүүлэн) болон хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

Зураг 4. Нэг иргэнээр тооцсон санхүүжилтээр 2023, 2024 онд үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, эзлэх хувь




2024 оны нэг иргэнээр тооцсон тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд үнэлгээ хийхэд 33 хувийг эрүүл мэндийг хянахад, 31.7 хувийг халдварт бус өвчний эрт илрүүлэгт, 20.5 хувийг эмчлэхэд, 6.7 хувийг эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөхөд, 4.1 хувийг өвчнөөс урьдчилан сэргийлэхэд, 3.3 хувийг халдварт өвчний илрүүлэгт, 0.7 хувийг сэргээн засах тусламж, үйлчилгээнд, 0.02 хувийг хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг болон 0.01 хувийг эрүүл мэндийг дэмжих үйлчилгээнд тус тус хийсэн байна. Өмнөх онтой харьцуулахад Халдварт бус өвчний илрүүлэг, эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ нэмэгдсэн байна.

Хүснэгт 22. Нэг иргэнээр санхүүжих гүйцэтгэлийн шалгуурын үнэлгээ, хуний тоогоор

Шалгуур	МД	2024 он		Гүйцэтгэлийн хувь
		Гүйцэтгэл	Хүрэх түвшин	
А	Б	1	2	3=1/2
Тавт вакцины 3 дахь тунгийн хамралтын хувь	1	41,134	56,044	73%
Жирэмсний хяналтад зургаа ба түүнээс дээш удаа хамрагдсан эхийн хувь	2	176,724	210,938	84%
Тухайн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүртгэлтэй хүн амын иргэдээс өвчний учир үзүүлсэн өвчтөнөөс лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад илгээсэн иргэний тоо	3	9,276	305,397	3%
Тухайн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд бүртгэлтэй хүн амаас хамгийн багадаа нэг удаа анхан шатны тусламж, үйлчилгээ авсан иргэдийн эзлэх хувь гүйцэтгэл	4	1,955,853	2,675,159	73%
Нийт үзлэг дотор эзлэх гэрийн эргэлтийн хувь	5	2,093,802	2,206,695	94%
35 ба түүнээс дээш насны эрсдэлт бүлгийн хүн амын дунд хоёрдугаар хэв шинжийн чихрийн шижин өвчний илрүүлгийн хувь гүйцэтгэл	6	834,677	1,433,632	58%
30–аас дээш насны эрсдэлт бүлгийн хүн амын дунд хорт хавдрын илрүүлэгт хамруулсан хувь гүйцэтгэл	7	825,053	1,502,443	55%

ЭМДҮЗ–ийн 2022 оны 13 дугаар тогтоолоор Анхан шатны эрүүл мэндийн байгууллагатай байгуулсан гэрээг 14 шалгуур үзүүлэлтээр үнэлэх журмыг баталж, хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд өрх, сум, тосгоны эрүүл мэндийн байгууллагуудын цахим системийн хөгжүүлэлтийн харилцан адилгүй байдлаас шалтгаалж зарим шалгуур үзүүлэлтийг үнэлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн тул шалгуур үзүүлэлтийн тоог цөөлж 2023 оны 07 дугаар тогтоолоор батлуулж сар бүрийн гүйцэтгэлийг цахим системээр үнэлж байна.

Зураг 5. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн дундаж оноо, нийт 80 онооноос, 2023–2024 он



Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг сар бүр цахим системд суурилан үнэлгээг хийж, шалгуур үзүүлэлтээр тогтмол хянадаг болсноос хойш анхан шатны тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийн үзүүлэлтүүд тасралтгүй сайжирж байна. Тухайлбал өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үр дүнгийн гүйцэтгэл эрс сайжирсан ба харин сумын эрүүл мэндийн төвүүдийн гүйцэтгэл сайжирч байгаа боловч хангалттай биш байна.

Хүснэгт 23. Анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, гүйцэтгэл (сая.төг)

Анхан шатны тусламж, үйлчилгээ	МД	2022 он	2023 он	2024 он	Өөрчлөлтийн хувь
А	Б	1	2	3	4=(3–2)/1
СТЭМТ–с үзүүлэх тусламж, үйлчилгээ (мөр 2:5)	**1**	**38,023.60**	**50,290.90**	**86,933.70**	**73%**
Шүд, амны хөндийн тусламж, үйлчилгээ	2	999.6	3,875.50	6,559.90	69%
Яаралтай тусламж	3	1,321.00	5,109.80	10,336.20	102%
Түргэн тусламж	4	6,771.20	11,231.70	21,465.00	91%
Хэвтүүлэн эмчлэх	5	28,931.80	30,073.90	48,572.50	62%
ӨСТЭМТ–өөс үзүүлэх тусламж, үйлчилгээ (мөр 7:11)	**6**	**14,334.00**	**34,083.70**	**55,022.60**	**61%**
Сэргээн засах	7	3,685.10	9,489.80	14,040.10	48%
Өдрийн эмчилгээ	8	5,190.50	11,343.30	17,507.20	54%
Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ	9	2,135.00	3,762.50	6,023.20	60%
Оношилгоо, шинжилгээ	10	3,323.40	9,488.00	16,968.60	79%
Шүд, амны хөндийн тусламж, үйлчилгээ	11	–	–	483.5	483%

Сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ, яаралтай, түргэн тусламж, шүд амны хөндийн үндсэн мэргэшлийн тусламж, үйлчилгээг тохиолдолд суурилсан аргаар лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагатай ижил тарифаар санхүүжүүлж байна.

2024 онд 86.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон, үүний 55.9 хувийг хэвтүүлэн эмчлэхэд, 24.7 хувийг яаралтай тусламжид, 11.9 хувийг түргэн тусламжид, 7.5 хувийг шүд, амны тусламж, үйлчилгээнд тус тус санхүүжүүлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 3 дугаар бүлгийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтын дагуу өрх, сум, тосгоны эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, зарим сэргээн засах тусламж, үйлчилгээг нэмэлтээр тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар санхүүжүүлж байна. 2024 онд 55.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон, үүний 30.8 хувийг оношилгоо, шинжилгээнд, 31.8 хувийг өдрийн эмчилгээнд, 25.5 хувийг сэргээн засах тусламж, үйлчилгээнд болон 10.9 хувийг гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээнд тус тус зарцуулсан байна.

4.2.ЛАВЛАГАА ШАТЛАЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ.

2024 онд ЭМДҮЗ–ийн 2023 оны 08 дугаар, 2024 оны 06 дугаар тогтоолын дагуу лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохицуулж эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтийг олгож ажилласан бөгөөд улсын хэмжээнд нийт гэрээ бүхий 314 эрүүл мэндийн байгууллагууд иргэд, даатгуулагчдад эрүүл мэндийн тусламж, тусламж, үйлчилгээг үзүүлж, эрүүл мэндийн даатгалын байгууллага давхардсан тоогоор 11.1 сая тусламж, үйлчилгээг худалдан авч, 1,422.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан байна.

Хүснэгт 24. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, нэр төрлөөр (сая.төг)


Төрөл	МД	2023 он		2024 он		Өөрчлөлтийн хувь	
		Тоо хэмжээ	Санхүүжилт	Тоо хэмжээ	Санхүүжилт	Тоо хэмжээ	Санхүүжилт
А	Б	1	2	3	4	5=(3–1)/1	6=(4–2)/2
Амбулаторийн тусламж, үйлчилгээ (мөр 2:6)	**1**	**7,340,512**	**226,919.3**	**7,481,336**	**300,052.3**	**1.9%**	**32.2%**
Амбулаторийн үзлэг	2	3,937,884	66,974.3	3,651,016	83,427.4	–7.3%	24.6%
Амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээний багц	3	2,018,139	109,970.3	2,174,936	142,851.8	7.8%	29.9%
Амбулаторийн хяналтын үзлэг	4	968,542	29,985.0	1,051,473	38,931.0	8.6%	29.8%
Амбулаториор хийгдэх мэс ажилбар	5	72,267	2,119.0	66,443	2,598.3	–8.1%	22.6%
Шүд, амны хөндийн амбулаторийн тусламж, үйлчилгээ	6	343,680	17,870.5	369,912	23,693.2	7.6%	32.6%
Жирэмсний хяналтын тусламж, үйлчилгээ				167,556	8,550.5		
Өдрийн бусад эмчилгээ (мөр 8:10)	**7**	**252,279**	**60,032.8**	**408,690**	**95,566.5**	**62.0%**	**59.2%**
Диализ	8	**221,394**	**31,466.1**	251,822	38,703.0	13.7%	23.0%
Хорт хавдрын туяаны өдрийн эмчилгээ	9	21,312	7,565.2	20,699	9,369.3	–2.9%	23.8%
Хорт хавдрын химийн өдрийн эмчилгээ	10	9,573	21,001.4	9,773	12,968.9	2.1%	–38.2%
Өдрийн эмчилгээ (мөр 12+13)	**11**	**93,686**	**22,482.3**	**126,396**	**4,492.6**	**34.9%**	**–80.0%**
Өдрийн мэс засал	12	12,322	3,101.3	13,114	4,492.6	6.4%	44.9%
Өдрийн эмийн эмчилгээ	13	81,364	19,381.0	113,282	30,032.6	39.2%	55.0%
Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ	**14**	**609,214**	**52,046.1**	**329,006**	**28,044.7**	**–46.0%**	**–46.1%**
Сувиллын тусламж, үйлчилгээ				**76,142**	**21,254.8**		

Төрөл	МД	2023 он		2024 он		Өөрчлөлтийн хувь	
		Тоо хэмжээ	Санхүүжилт	Тоо хэмжээ	Санхүүжилт	Тоо хэмжээ	Санхүүжилт
А	Б	1	2	3	4	5=(3–1)/1	6=(4–2)/2
Амбулаторийн үзлэг	16	186,722	3,732.4	238,626	5,036.5	27.8%	34.9%
Өдрийн эмчилгээ	17	14,822	2,221.4	20,575	5,865.3	38.8%	164.0%
Хэвтүүлэн эмчлэх	18	97,005	46,646.1	42,887	25,796.8	–55.8%	–44.7%
Телемедициний тусламж, үйлчилгээ	**19**	**719**	**38.8**	**717**	**38.4**	**–0.3%**	**–0.9%**
Түргэн тусламж	**20**	**523,064**	**28,028.0**	**558,807**	**32,553.7**	**6.8%**	**16.1%**
Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ (мөр 22:24)	**21**	**318,041**	**56,570.0**	**323,512**	**45,762.2**	**1.7%**	**–19.1%**
Амбулаторийн үзлэг	22	198,663	3,967.9	229,546	4,884.5	15.5%	23.1%
Өдрийн эмчилгээ	23	18,584	2,683.4	24,354	4,052.0	31.0%	51.0%
Хэвтүүлэн эмчлэх	24	100,794	49,918.7	69,612	36,825.7	–30.9%	–26.2%
Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ	**25**	**7,963**	**6,994.7**	**8,859**	**8,487.4**	**11.3%**	**21.3%**
Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ (мөр 27:31)	**26**	**718,695**	**689,043.8**	**730,139**	**797,287.9**	**1.6%**	**15.7%**
Мэс засал	27	154,814	282,185.0	172,776	330,869.4	11.6%	17.3%
Хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх хими, туяа эмчилгээ	28	12,306	27,753.8	13,739	22,231.6	11.6%	–19.9%
Эмийн эмчилгээ	29	535,267	319,781.5	522,804	366,390.5	–2.3%	14.6%
Эрхтэн шилжүүлэх мэс засал	30	148	13,008.2	160	14,179.0	8.1%	9.0%
Эрчимт эмчилгээ	31	16,160	46,315.4	20,660	63,617.4	27.8%	37.4%
Яаралтай тусламж	**32**	**806,194**	**66,342.6**	**972,747**	**56,385.4**	**20.7%**	**–15.0%**
Нийт дүн (мөр 1+7+11+14+15 + 19 + 20 + 21 + 25 + 26 + 32)	**33**	**10,968,916**	**1,261,098.5**	**11,192,043**	**1,422,131.9**	**2.0%**	**12.8%**

2024 онд лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд 2,069.238 даатгуулагчийг хамруулж, давхардсан тоогоор 11,1 сая тусламж, үйлчилгээг хянаж санхүүжүүлсэн байна. 2023 онтой харьцуулахад тусламж, үйлчилгээнд хамрагдсан хүний тоо 4.8 хувиар, тохиолдлын хувьд 2 хувиар, санхүүжилтийн хувьд 12.8 хувиар тус тус өссөн байна.

2024 оны байдлаар даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардлын төрлөөр авч үзвэл хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд 56.1 хувийг, амбулаторийн тусламж, үйлчилгээнд 21.1 хувийг, өдрөөр үзүүлэх тусламж, үйлчилгээнд 6.7 хувийг, яаралтай тусламж, үйлчилгээнд 4 хувийг, түргэн тусламж, үйлчилгээнд 2.3 хувийг, сэргээн засах тусламж, үйлчилгээнд 2.6 хувийг, уламжлалтын тусламж, үйлчилгээнд 3.2 хувийг, өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээнд 2 хувийг, сувилалаас үзүүлэх тусламж, үйлчилгээнд 1.5 хувийг, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд 0.5 хувийг тус тус зарцуулсан байна.

Зураг 6. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад олгосон санхүүжилт (тэрбум төг)



Гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн байгууллагын санхүүжилт жил бүр үе шаттайгаар нэмэгдсээр байна. 2022 онд санхүүжилт өндөр байгаа нь Ковид–19 цар тахлын үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас он дамжуулан санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 25. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, эрүүл мэндийн байгууллагын төрлөөр (сая.төг)

ЭМБ–н төрөл	МД	2022 он		2023 он		2024 он	
		Санхүүжилт	Эзлэх хувь	Санхүүжилт	Эзлэх хувь	Санхүүжилт	Эзлэх хувь
А	Б	1	2	3	4		
Нэгдсэн эмнэлэг	1	451,923.7	44.0%	555,111.8	44%	681,715.6	48.0%
Ортой клиник	2	67,782.9	7.0%	97,278.0	8%	107,500.6	7.0%
Оргүй клиник	3	1,487.0	0.0%	13,982.0	1%	18,667.5	1.0%
Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	4	418,923.1	41.0%	457,236.0	36%	477,700.4	33.0%
Амаржих газар	5	23,162.3	2.0%	30,184.8	2%	35,221.5	2.5%
Түргэн тусламжийн төв	6	13,307.9	1.0%	18,247.9	1%	21,007.1	2.0%
Тусгай эмнэлэг	7	18,684.6	2.0%	22,433.6	2%	23,262.9	2.0%
Уламжлалт нэгдсэн эмнэлэг	8	13,461.8	1.0%	17,769.0	1%	21,059.8	2.0%
Сэргээн засах төв	9	2,304.1	0.0%	11,193.8	1%	8,844.2	1.0%
Сувилал	10	21,907.5	2.0%	37,661.6	3%	27,167.0	2.0%
Нийт дүн (мөр 1:10)	**11**	**1,032,944.9**	**100%**	**1,261,098.5**	**100%**	**1,422,131.4**	**100%**

Эх үүсвэр: ЭМДЕГ 2022–2024 он

Эмнэлгийн тусламж, үйлчилгээг байгууллагын төрлөөр харьцуулж нэгдсэн эмнэлэг 44 хувийг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг 36 хувийг буюу дийлэнх хувийг эзэлж байна.

Тусламж, үйлчилгээний ачааллыг тэнцвэржүүлэх, төвлөрлийг сааруулах бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх тусламж, үйлчилгээг үндсэн мэргэжлийн болон төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээгээр ангилж, ялгавартай тарифаар санхүүжүүлж байна.

Түүнчлэн Монгол Улсын өргөн уудам газар нутагт тархан байршсан байдал, Монгол Улсад импортоор орж ирсэн гол нэрийн бүтээгдэхүүнийг голчлон УБ хотоос түгээж байгаа нь УБ хотоос алслагдмал орших орон нутгийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөд шууд нөлөө үзүүлж байна. Нэн ялангуяа алслагдсан аймаг, сум, багт ажиллах эрүүл мэндийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх боломж хомс байна. Иймд эрүүл мэндийн даатгалын сангаас олгож байгаа тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд бүсчлэлийн коэффициентыг (Баруун бүс–1.15, хангайн бүс–1.1, Төвийн бүс–1.05, Зүүн бүс–1.05, Улаанбаатар–1) тохируулж 2024 оны 01 дүгээр сарын 01–нээс хэрэгжүүлж эхэлсэн. Жишээлбэл: Баруун бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа ЭМБ–ууд нь УБ хотод үйл ажиллагаа явуулж байсан эмнэлгүүдээс 15 хувиар илүү тарифаар Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ гэсэн үг юм. Ингэснээр иргэн оршин байгаа газраа санхүүгийн ямар нэгэн эрсдэлд орохгүйгээр шаардлагатай тусламж, үйлчилгээг авах боломжийг бүрдүүллээ.

4.3.УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлсан “Алсын хараа–2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021–2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”–ны хөтөлбөрт иргэн бүрийг 2 жил тутамд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд тогтмол хамруулж хэвшүүлэхээр, Монгол Улсыг 2021–2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргийлж болох нас баралтын түвшнийг бууруулна гэж тус тус заасан байдаг.

Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах нь тухайн хүний эрүүл мэнд, өвчин эмгэгийг эрт үед нь илрүүлэх, үр дүнтэй эмчлэх, ирээдүйд учирч болзошгүй хүндрэл, нас баралт, санхүүгийн дарамтаас сэргийлэх ач холбогдолтой. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлээс өмнө төр хариуцан төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөлд хорт хавдар, хүүхэд, төрөх, эмэгтэйчүүд, халдварт өвчнүүд нь эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд байдаггүй учраас эрт илрүүлгийн багцад хамруулдаггүй байсан. Харин нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжсэнээр салангид байсан багцуудыг нэгтгэж, эрт илрүүлгийг үзлэг, шинжилгээг цогц байдлаар хийх боломж бүрдсэн.

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 05 дугаар сарын 01–ний өдрөөс улс орон даяар эрт илрүүлгийн багцын үзлэг, оношилгоо, шинжилгээнд иргэдийг хамруулахаар чиглэл өгөгдсөний дагуу Эрүүл мэндийн

сайдын 2023 оны А/379 дугаар тушаалаар холбогдох журмыг батлуулж, ЭМДҮЗ-ийн 2023 оны 10 дугаар тогтоолын дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний багцын тусламж, үйлчилгээг нийт 81 эрүүл мэндийн байгууллага, үүнээс 47 (58 хувь) төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага, 34 (42 хувь) хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудтай гэрээ байгуулан санхүүжүүлж байна. Эдгээр эрүүл мэндийн байгууллагын 40 (49 хувь) нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулдаг, үлдсэн 41 (51 хувь) нь Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулдаг эрүүл мэндийн байгууллагууд байна.

Хүснэгт 26. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээний тоо, (давхардсан)

Илрүүлэх өвчин эмгэг	МД	Оношилгоо, шинжилгээний тоо		
		2022 он	2023 он	2024 он
А	Б	1	2	3
Бамбайн өвчний илрүүлэг	1	85,531	219,469	157,762
Бөөр, шээсний замын өвчний илрүүлэг	2	576,996	1,085,084	763,900
Бүдүүн шулуун гэдэсний хавдар	3	68,093	166,309	83,483
Бэлгийн замаар дамжих халдварын илрүүлэг	4	106,045	188,232	200,139
Гепатитын В, С вирусийн халдварын илрүүлэг	5	308,587	723,025	411,801
Зүрх, судасны эмгэгийн илрүүлэг	6	616,320	1,446,012	625,048
Сүрьеэ өвчний илрүүлэг	7	151,789	718,071	3,556
Умайн хүзүүний хавдрын илрүүлэг	8	15,096	47,976	27,095
Уушгины эмгэгийн илрүүлэг	9	151,789	357,517	204,551
Хоёрдугаар хэв шинжийн чихрийн шижингийн илрүүлэг	10	85,861	221,418	189,164
Хоол боловсруулах замын эмгэгийн илрүүлэг	11	817,705	894,547	1,070,243
Хөхний хавдрын илрүүлэг	12	56,367	139,059	132,679
Элэгний хавдрын илрүүлэг	13	113,677	1,383,129	179,136
Нийт (мөр 1:13)	**14**	**3,153,856**	**7,589,848**	**4,048,557**

2024 онд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг, оношилгоо шинжилгээгээр 13 төрлийн өвчин эмгэгийг илрүүлэх зорилгоор давхардсан байдлаар 4.0 сая оношилгоо, шинжилгээг хийсэн бөгөөд хамгийн их буюу 26.4 хувийг хоол боловсруулах замын эмгэгийн илрүүлэг, 18.9 хувь нь бөөр, шээсний замын өвчний илрүүлэг, 15.4 хувь нь зүрх, судасны эмгэгийн илрүүлэг үзлэгт тус тус иргэд хамрагдсан байна.

Хүснэгт 27. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээний тоо, 2024 он

Илрүүлэх өвчин эмгэг	МД	18–30 насны багц	34–45 насны багц	46–60 насны багц	61–дээш насны багц
А	Б	1	2	3	4
Бамбайн өвчний илрүүлэг	1	–	73,253	57,528	26,981
Бөөр, шээсний замын өвчний илрүүлэг	2	112,069	322,137	223,511	106,183
Бүдүүн, шулуун гэдэсний хавдар	3	–	–	56,834	26,649
Бэлгийн замаар дамжих халдварын илрүүлэг	4	71,056	129,083	–	–
Гепатитын В, С вирусийн халдварын илрүүлэг	5	71,509	167,441	117,413	55,438
Зүрх, судасны эмгэгийн илрүүлэг	6	109,617	252,035	178,585	84,811
Сүрьеэ өвчний илрүүлэг	7	1,040	1,607	538	371
Умайн хүзүүний хавдрын илрүүлэг	8	1,689	15,303	10,103	–
Уушгины эмгэгийн илрүүлэг	9	36,315	82,637	58,189	27,410
Хоёрдугаар хэв шинжийн чихрийн шижингийн илрүүлэг	10	1,791	85,465	69,066	32,842
Хоол боловсруулах замын эмгэгийн илрүүлэг	11	143,840	458,516	321,078	146,809
Хөхний хавдрын илрүүлэг	12	20,714	55,060	38,915	17,990
Элэгний хавдрын илрүүлэг	13	12,982	82,975	56,793	26,386
Нийт	**14**	**582,622**	**1,725,512**	**1,188,553**	**551,870**

2022 онд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн гүйцэтгэлээр 147,423 тохиолдолд 16.4 тэрбум төгрөг, 2023 онд 357,387 тохиолдолд 42.6 тэрбум төгрөг, 2024 онд 219,206 тохиолдолд 31.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын сангаас тус тус олгосон.

Хүснэгт 28. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт олгосон санхүүжилт, багцын эзлэх хувь

Багцын нэр	МД	2022 он			2023 он			2024 он		
		Хамруулсан хүн ам	Зарцуулсан мөнгөн дүн сая төг	Эзлэх хувь	Хамруулсан хүн ам	Зарцуулсан мөнгөн дүн сая төг	Эзлэх хувь	Хамруулсан хүн ам	Зарцуулсан мөнгөн дүн сая төг	Эзлэх хувь
А	Б	1	2	3	4	5	6			
18–30	1	38,759	2,318.4	14%	60,656	3,623.0	9%	37,468	3,104.4	10%
31–45	2	42,725	5,212.7	32%	130,514	16,054.9	38%	89,200	13,105.0	41%
46–60	3	39,561	5,485.9	33%	113,701	16,031.5	38%	62,880	10,865.3	34%
61+	4	26,378	3,385.7	21%	52,516	6,899.5	16%	29,658	4,551.7	14%
Нийт дүн (мөр 1:4)		**147,423**	**16,402.70**	**100%**	**357,387**	**42,608.97**	**100%**	**219,206**	**31,626.3**	**100%**

Эх үүсвэр: ЭМДЕГ 2022–2024 он

Нийт үзлэгийн 72 хувь (161,022)–ийг төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага, 27 хувь (58,184)–ийг хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага хийж байгаа нь цаашид хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

4.4.ЭМИЙН ҮНИЙН ХӨНГӨЛӨЛТ.

Эмийн үнийн хөнгөлөлтийн багцын хүрээнд амбулаториор эмчлэх боломжтой өвчний эмийг шаардлагатай даатгуулагчид нь санхүүгийн дарамтгүйгээр хүргэх замаар хэвтэн эмчлүүлэх үйлчилгээний тоог бууруулах, хүн амыг эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс хамгаалах, сангийн үр ашгийг дээшлүүлэх зорилготой ажиллаж байна.

Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэлийг эхлүүлснээс хойш буюу 2020 оноос хөнгөлөлттэй эмийн нэр төрөл, үнэ, хөнгөлөлттэй эмийн аргачлалыг шинэчилж, ЭМДҮЗ–ийн 2020 оны 13, 2022 оны 11 дүгээр тогтоолоор тус тус хэрэгжүүлсэн байна.

ЭМДҮЗ–ийн 2022 оны 11 дүгээр тогтоолын дагуу 156 өвчний үед хэрэглэх 161 эмд хамаарах 651 худалдааны нэршлийн эмийг 30, 50, 70, 100 хувийн хөнгөлөлт үзүүлж байна. Үүнээс 0–19 хүртэлх насны хүүхдэд уналт, таталт өвчнийг эмчлэх 15 өрөнхий нэршлийн 77 эмд буюу, “Новартис эмийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр”–ийн 15 өрөнхий нэршлийн 26 эмд эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувийн хөнгөлөлт олгосон байна.

Хүснэгт 29. Эмийн үнийн хөнгөлөлтийн хүртээмж

Төрөл	МД	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
А	Б	3	4	5	6	
Монгол Улсын хүн амын тоо	1	3,357,542	3,409,939	3,457,548	3,504,741	3,544,835
Хөнгөлөлттэй эм авсан даатгуулагчийн тоо	2	406,503	508,837	572,568	645,852	784,603
Хөнгөлөлттэй эмийн хүртээмжийн хувь, нийт хүн амд тооцсоноор	3	12.1%	14.9%	16.5%	18.4%	22.1%

2024 оны байдлаар нийт 784.6 мянган даатгуулагч хөнгөлттэй эм авсан буюу Монгол Улсын нийт хүн амын 22.1 хувьд нь хүрч байна. Мөн хөнгөлөлттэй эмийн тусламж, үйлчилгээг авч байгаа даатгуулагчийн тоо 2020–2024 онд 1.9 дахин өссөн. Харин амьсгалын замын өвчлөл болох ханиад, томууны эмүүдийг иргэд өөрсдөө худалдан авч байна.

Хүснэгт 30. Эмийн үнийн хөнгөлөлтийн гүйцэтгэл (сая.төг)

Эмийн ангилал	МД	2023 он		2024 он		Өөрчлөлтийн хувь	
		Тохиолдлын тоо	Санхүүжилт	Тохиолдлын тоо	Санхүүжилт	Тохиолдлын тоо	Санхүүжилт
А	Б	3	4	5	6	7=(5–3)/3	8=(6–4)/4
Амьсгалын эрхтэний үйл ажиллагаанд нөлөөлөх бэлдмэл	1	52,853	1,568,094	87,551	2,506,699	66%	60%
Арьсны өвчнийг эмчлэх бэлдмэл	2	904	4,938	1,159	6,382	28%	29%
Бөөр, шээсний замд нөлөөлөх эм	3	73,055	2,031,523	92,610	2,635,112	27%	30%
Вирусийн эсрэг бэлдмэл	4	69,778	4,284,644	133,542	7,269,510	91%	70%
Даавар, дааврын үйлдэлт бусад бэлдмэл	5	36,947	206,073	46,352	266,709	25%	29%
Дархлаа дарангуйлах эм	6	–	–	5,025	992,353		
Зүрх, судасны тогтолцоонд нөлөөлөх эм	7	2148630	33,738,558	2,438,116	46,400,071	13%	38%
Нүдний өвчинд хэрэглэх бэлдмэл	8	8,839	138,690	13,410	288,730	52%	108%
Өвдөлт намдаах, халуун бууруулах, үрэвслийн эсрэг эм	9	138,379	282,143	162,048	342,720	17%	21%
Паркинсон өвчний эмчлэх эм	10	2,064	115,290	2,118	101,703	3%	–12%
Сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийг эмчлэх эм	11	106,608	3,556,266	141,859	5,377,152	33%	51%
Уналт, таталтын эсрэг эм	12	156,598	4,416,900	161,633	6,048,438	3%	37%
Үе мөчний эмгэгт нөлөөлөх бэлдмэл	13	20,454	409,775	29,947	611,285	46%	49%
Хавдрын эсрэг, дархлаа дарангуйлах, хөнгөвчлөх эмчилгээний бэлдвэл	14	9,827	838,966	6,137	61,359	–38%	–93%
Халдварын эсрэг бэлдмэл	15	354,956	3,902,303	523,499	6,710,774	47%	72%
Харшлын ба анафи–лаксийн эсрэг эм	16	8,819	97,553	10,322	118,110	17%	21%
Ходоод гэдэсний замын эмгэгүүдэд хэрэглэх бэлдмэл	17	508,814	11,334,817	602,032	18,219,735	18%	61%

Цусны тогтолцоонд нөлөөлөх бэлдмэл	18	342,613	12,419,212	465,304	18,884,597	36%	52%
Чих хамар хоолойн өвчинд хэрэглэх бэлдмэл	19	241	3,553	676	10,174	180%	186%
Чихрийн шижин эмчлэх	20	185,604	7,407,271	251,341	13,556,756	35%	83%
Түрүү булчирхайн эмгэгт хэрэглэх эм	21	89,969	3,362,798	107,730	4,148,918	20%	23%
Нийт дүн (мөр 1:21)	**22**	**4,315,952**	**90,119,368**	**5,282,411**	**134,557,287**	**22%**	**49%**

Эх үүсвэр: ЭМДЕГ 2023–2024он

Эрүүл мэндийн даатгалын сангаас жороор олгох эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо нь өмнөх онтой харьцуулахад 2024 онд 22 хувиар, санхүүжилт нь 49 хувиар тус тус өссөн байна. Нийт олгосон санхүүжилтийн 4.5 хувийг Зүрх, судасны тогтолцоонд нөлөөлөх эмийн бэлдмэл, 14 хувийг Цусны эргэлтийн тогтолцоонд нөлөөлөх эм, 13.5 хувийг Ходоод, гэдэсний замын эмгэг, 10.1 хувийг Чихрийн шижингийн эм тус тус эзэлж байна.

Хүснэгт 31. Эмийн үнийн хөнгөлөлт, хөнгөлөлтийн хувиар (сая.төг)

Хөнгөлөлтийн хувь	МД	2022 он		2023 он		2024 он	
		Тохиолдлын тоо	Олгосон санхүүжилт	Тохиолдлын тоо	Олгосон санхүүжилт	Тохиолдлын тоо	Олгосон санхүүжилт
А	Б	1	2	3	4	5	6
30%	1	665,131	7,062.8	984,889	10,460.2	512,940	3,775.1
50%	2	1,070,873	18,166.1	843,403	19,559.7	1,532,795	33,296.0
70%	3	2,154,423	54,204.8	1,809,036	56,859.9	2,556,188	94,185.3
100%	4	12,870	4,818.0	685749	8,804.9	680,488	3,300.9
Нийт дүн (мөр 1:4)	**6**	**3,903,297**	**84,251.7**	**4,323,077**	**95,684.6**	**5,282,411**	**134,557.3**

Эх үүсвэр: ЭМДЕГ 2022–2024он

2024 онд 5.3 сая эмийг эрүүл мэндийн даатгалын сангаас жороор олгох эмийн үнийн хөнгөлөлтийг санхүүжүүлсэн бөгөөд эдгээр жорын 12.9 хувийг 100 хувь, 48.4 хувийг 70 хувь, 29 хувийг 50 хувь, 9.7 хувийг 30 хувь тус тус хөнгөлөлт үзүүлсэн байна. Хөнгөлөлттэй эмийн жорын тохиолдлын тоо өмнөх оноос 959.3 мянгаар, санхүүжилт 38.8 тэрбумаар тус тус өссөн байна.

ЭМДҮЗ–ийн 2022 оны 11 дүгээр тогтоолын хэрэгжилтэд явцын үнэлгээ хийсэн бөгөөд 2024 оны байдлаар эмийн үнийн хөнгөлөлтөд хамрагдсан 784.6 мянган даатгуулагчийн 162.0 мянган даатгуулагч нь тогтмол эм хэрэглэж байна. Хөнгөлөлт авах үедээ даатгуулагчийн эмийн санд төлж байгаа хамтын төлбөрийн дундаж хувь 38.2 байна. Монгол Улсад бүртгэлтэй, амбулаториор хэрэглэх боломжтой нийт эмийн 20 орчим хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлтөд хамруулж байна.

Эмийн үнийн хөнгөлөлт авч байгаа нийт даатгуулагчийг шимтгэл төлөлтийн ангилалаар авч үзвэл 3 даатгуулагч тутмын 2 нь тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн байна. Дээрх тоон мэдээллүүд нь даатгуулагчдад үзүүлэх эмийн үнийн хөнгөлөлтийн тусламж, үйлчилгээг илүү хүртээмжтэй болгох, даатгуулагчийг эм худалдан авахтай холбоотой үүсэх санхүүгийн дарамтыг нь бууруулах, эмийн нэр төрлийг өргөжүүлэх болон үнийн уян хатан бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

4.5. ТӨРӨӨС ТӨЛБӨРИЙГ НЬ ХАРИУЦАХ ЭМИЙН ГҮЙЦЭТГЭЛ.

Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.7–т “удаан хугацааны нөхөх эмчилгээ шаардах эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний зарим эмийн зардал”–ыг төрөөс хариуцахаар заасны дагуу Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/407 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж, эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулан санхүүжүүлж байна.

Хүснэгт 32. Төрөөс төлбөрийг нь хариуцах эмийн санхүүжилт

Төрөл	МД	2021 он	2022 он	2023 он	2024 он	Өөрчлөлт хувь
А	Б	1	2	3	4	5=(4–3)/3
Сүрьеэ /A15–A18/	1	989.2	849.2	785.0	1,042.5	33%
Хорт хавдрын 3,4–р үе	2	207.0	239.7	286.1	527.0	84%
Сэтгэц,зан үйлийн эмгэг	3	64.7	68.9	243.0	250.4	3%
Чихрийн шижин	4	1,858.6	2,595.0	4,280.2	5,192.8	21%
Чихрийн бус шижин	5	118.6	139.2	216.0	232.7	8%
Бамбай булчирхайн дутмагшил /E01–03/	6	15.0	19.2	61.5	72.4	18%
Өнчин дааврын тархины шалтгаант өсөлтийн дааварын дутмагшил /E23/	7	53.3	69.3	40.8	6.6	–84%
Паркинсоны өвчин /G20/	8	34.9	47.0	61.8	87.1	41%
Уналт таталт (Эпилепси) /G40–G41/	9	68.4	72.4	99.8	138.3	39%
Миастени /G70/	10	–	–	6.6	–	–100%
Нүдний даралт ихсэх өвчин (Глаукома) /H40–H42/	11	1.4	0.7	3.4	2.3	–34%
Эрхтэн шилжүүлж суулгасны дараах байдал	12	3,006.3	4,603.6	5,264.1	6,517.5	24%
Дархлалын олдмол хомсдол өвчин	13	6.2	9.7	–	0.8	
Гемофилий /D65–69/	14	–	–	–	–	
Бөөрний дутагдал /N17–19/	15	356.4	541.7	–	–	
Тархмал хатуурал	16				6.0	
Хорт хавдрын дараах хими бай эмчилгээний эм	17				20,111.1	
Хорт хавдрын дархлаа эмчилгээ	18				1,087.5	
Цочмог промиелоцитын лейкеми, Архаг лимфолейкеми лимфомууд, Архаг миелопролифератив эмгэгүүд	19				0.9	
Нийт дүн (мөр 1:19)	20	**6,944.5**	**9,269.9**	**11,348.4**	**35,275.9**	**211%**

Эх үүсвэр: ЭМДЕГ, 2021–2024 он

Төлбөрийг нь төр хариуцах эмийг 2024 оны байдлаар Монгол Улсын 21 аймаг болон Нийслэлд нийтдээ 46 эрүүл мэндийн байгууллага олгож байна. Санхүүжилтийн хувьд өмнөх оноос 2 дахин нэмэгдсэн шалтгаан нь хорт хавдрын дараах химийн бай эмчилгээ болон хорт хавдрын эмчилгээний шинэ технологи болох дархлаа эмчилгээний эмийн зардлыг тохиолдол бүрээр нь санхүүжүүлэх болсонтой холбоотой байна.

Хүснэгт 33: Төлбөрийг нь төр хариуцах өвчний үед хэрэглэгдэх эм, эрүүл мэндийн байгууллагуудын нэхэмжлэл

№	Өвчний ангилал	Эмийн тоо, баркодоор/	Нэхэмжлэл ирүүлсэн эсэх	
			Тийм	Үгүй
1	Гемофилли	9		9
2	Гипотиреоз	18	7	11
3	Глаукома	10		10
4	Дархлалын олдмол хомсдол өвчин	14		14
5	Өнчин тархины шалтгаант өсөлтийн дааврын дутмагшил	3	1	2
6	Паркинсоны өвчнөөс үүдэлтэй зөнөгрөл болон бусад шалтгааны зөнөгрөл, Алцгеймэрын өвчин	4	2	2
7	Сүрьеэ	69		69
8	Сэтгэц, зан үйлийн эмгэг	51	26	25
9	Тархмал хатуурал	4		4
10	Уналт таталт, Эпилепси	125	19	106
11	Хорт хавдрын 3,4 үе шат /Хөнгөвчлөх эмчилгээ/	32	18	14
12	Хорт хавдрын бай эмчилгээний эм	66	45	21
13	Хорт хавдрын дархлаа эмчилгээ	8	2	6
14	Цочмог промиелоцитын лейкеми, Архаг лимфолейкеми лимфомууд, Архаг миелопролифератив эмгэгүүд	6		6
15	Чихрийн бус шижин	4	3	1
16	Чихрийн шижин	78	45	33
17	Эрхтэн шилжүүлж суулгасны дараах байдал	29	10	19
	Нийт	**530**	**178**	**352**

2024 оны байдлаар Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/407 дугаар тушаалаар батлсан “Төлбөрийг нь төр хариуцах өвчний жагсаалт”–д тусгагдсан 17 өвчний үед хэрэглэх 530 худалдааны нэршлийн эмээс 178 худалдааны нэршлээр эрүүл мэндийн байгууллагуудаас нэхэмжлэл ирүүлсэн байна. Эрүүл мэндийн байгууллагууд төлбөрийг нь төр хариуцах эмийн худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахгүй, эмийн нөөцийг бүрдүүлж ажиллахгүй байгаагаас тусламж, үйлчилгээний хүртээмж хангалтгүй хэвээр байна.

Төлбөрийг нь төр хариуцах өвчний жагсаалтаас “Уналт, таталт” өвчний үед хүүхдэд хэрэглэгдэх 15 төрлийн эмийг 2022 оны 10 дугаар сараас эхлэн эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулан санхүүжүүлж эхэлсэн. Энэхүү өвчний үед хэрэглэгдэх эмүүдийг 0–19 хүртэлх насны хүүхдүүдэд 100 хувь, насанд хүрэгчдэд 70 хувийн хөнгөлөлтийг үзүүлж байна.

Хүснэгт 34: Уналт, таталт өвчний үед хэрэглэгдсэн эмийн нэр төрөл, санхүүжилт

Эмийн олон улсын нэршил	2022 он		2023 он		2024 он	
	Тохиолдлын тоо	Мөнгөн дүн / мян/	Тохиолдлын тоо	Мөнгөн дүн / мян/	Тохиолдлын тоо	Мөнгөн дүн / мян/
Вальпроны хүчил	5,021	321,093	7,489	581,370	7,473	656,399
Габапентин	82,716	1,610,543	88,310	1,737,085	76,041	1,455,171
Диазепам	232	703	249	657	267	672
Зонисамид	2	61	19	1,386	129	11,544
Карбамазепин	44,132	778,464	51,708	1,227,128	59,490	1,598,994
Клоназепам	101	346	301	1,043	597	2,051
Лакосамид	15	1,067	158	18,102	1,110	128,707
Ламотриджин	101	19,600	775	196,862	1,656	483,719
Леветирацетам	2,086	183,982	3,662	568,127	5,281	1,003,571
Окскарбазепин	137	21,564	1,083	257,422	1,644	407,147
Прегабалин	771	16,085	2,077	68,117	6,932	233,989
Топирамат	321	12,657	363	38,127	402	61,376
Фенитоин		–	60	930	101	1,633
Фенобарбитал	173	1,277	344	2,481	510	3,464
Нийт дүн	**135,808**	**2,967,440**	**156,598**	**4,698,838**	**161,633**	**6,048,438**

2024 оны байдлаар “Уналт, таталт” өвчний үед хэрэглэгдэх 13 нэр төрлийн эмийг 78.891 хүүхдэд, давхардсан тоогоор 161.6 мянган тохиолдолд 6 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувиар хөнгөлт үзүүлж санхүүжүүлсэн байна.

4.6. НОВАРТИС ЭМИЙН ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ХӨТӨЛБӨР

ЭМДҮЗ–ийн 2022 оны 11 дүгээр тогтоолоор “Новартис эмийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр”–ийн 15 ерөнхий нэршлийн 26 эмийг эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувийн хөнгөлөлт олгож ажилласан. Хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн даатгалын сангаас 2022 онд 683.9 сая төгрөг, 2023 онд 3 тэрбум төгрөг, 2024 онд 3.3 тэрбум төгрөгийн зардлыг иргэн, даатгуулагчийн өмнөөс төлж, даатгуулагч төлөх байсан 21 тэрбум төгрөгийг хэмнэсэн байна.

Хүснэгт 35. Новартис эмийн хүний тоо, тохиолдол, санхүүжилт 2023–2024 он

№	Эмийн олон улсын нэршил	2023 он			2024 он		
		Хүний тоо	Тохиолдлын тоо	Мөнгөн дүн /мян/	Хүний тоо	Тохиолдлын тоо	Мөнгөн дүн /мян/
1	Амлодипин			–	44,544	91,633	484,702
2	Амлодипин	82,949	224,966	984,228	64,631	139,677	652,813
3	Амлодипин			–	4,996	6,878	40,619
4	Амлодипин	14,745	27,976	138,812	14,958	24,867	142,240
5	Амоксициллин	25,312	30,627	89,711	31,519	37,105	107,844
6	Анастрозол	209	394	1,721	386	1,035	4,718
7	Аторвастатин	6,197	7,948	38,444	19,853	29,916	194,486
8	Аторвастатин	45,553	70,576	331,074	28,182	37,627	179,756
9	Бисопролол	17,150	34,748	134,993	26,548	54,690	211,670
10	Бисопролол	5,620	8,125	36,551	3,039	3,990	17,842
11	Бисопролол	41,051	79,562	323,838	36,566	64,852	268,988
12	Фуросемид	1,754	2,216	9,612	1,216	1,595	6,857
13	Глимепирид	277	376	2,268	278	517	2,950
14	Глимепирид	2,767	4,991	24,341	4,263	11,844	55,598
15	Глимепирид	1,961	3,786	17,216	2,821	7,998	36,295
16	Гидрохлортиазид	1,101	1,373	6,988	330	388	2,124
17	Летрозол	610	2,779	12,096	537	1,317	5,715
18	Метформин	12,861	32,079	120,079	15,788	46,609	180,552
19	Метформин	8,756	19,197	77,127	7,829	16,561	66,292
20	Рамиприл	2,432	5,573	23,614	2,185	4,649	20,606
21	Рамиприл	692	1,381	10,128	557	944	7,190
22	Салбутамол	3,481	6,971	30,399	2,745	5,552	24,295
23	Тамоксифен	241	879	3,827	435	1,624	7,098
24	Валсартан	22,117	48,492	241,349	6,632	9,941	51,677
25	Валсартан	22,135	48,668	296,100	25,959	64,674	469,682
26	Вилдаглиптин	8,025	20,230	80,863	6,116	14,020	58,325
	Нийт	**228,507**	**683,913**	**3,035,377**	**232,216**	**680,503**	**3,300,935**

2024 оны байдлаар Новартис хөтөлбөрийн хүрээнд 232.2 мянган даатгуулагчдад 680.5 мянган тохиолдолд 3,3 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж ажилласан байна. Нийт санхүүжилтийн 40 хувийг Амлодипин,15.8 хувийг Валсартан, 15.1 хувийг Бисопролол эмүүдэд тус тус зарцуулсан байна.

5 ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ДААТГУУЛАГЧДЫН ҮЗҮҮЛЭЛТ БА ҮР ДҮН

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын үндсэн гол үүрэг нь Эрүүл мэндийн даатгалын санг бүрдүүлэх, бүрдүүлсэн сангаас авах тусламж, үйлчилгээг тогтоох, тусламж, үйлчилгээг хэнээс, ямар аргаар, ямар үнээр худалдан авахыг шийдэхийн зэрэгцээ тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавьж, чанартай тусламж, үйлчилгээг худалдан авдаг.

Санхүүжилтийн шинэчлэлийг эхлүүлэх үед эмнэлгийн тусламж, үйлчилгээнд дараах үндсэн 5 зорилтыг хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн. Үүнд:

1. Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг бүрэн хариуцах
2. Эмзэг бүлгийн иргэдийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах
3. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх шаардлагагүй хэвтэлтийг бууруулах
4. Тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах
5. ЭМД–ын сангаас иргэнд тавьж буй санхүүгийн хязгаарыг арилгах

ЭМДЕГ–ын нэхэмжлэл, үйл ажиллагааны тайланд дүн шинжилгээ хийхэд дэвшүүлсэн зорилтод хүрсэн эсэхийг үнэлэхэд дараах байдалтай байна.

1.Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг бүрэн хариуцах: Эрүүл мэндийн тухай хуулийн дагуу төрөх, жирэмсэн, нярайн тусламж, үйлчилгээ, халдварт өвчин, яаралтай тусламж, түргэн тусламж зэрэг нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний зардлыг төр хариуцдаг. Уг хуулийн хэрэгжилтийг хангуулахын зэрэгцээ иргэн даатгуулагчийн амь насанд гэнэтийн эрсдэл учруулж болзошгүй зүрх, тархины мэс засал болон хорт хавдрын бүх төрлийн тусламж, үйлчилгээг хамтын төлбөргүйгээр, эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувь хариуцан санхүүжүүлдэг болсон.


2.Эмзэг бүлгийн иргэдийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах: Эрүүл мэндийн даатгалын зарчим нь эмзэг бүлгийн иргэдийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах бөгөөд шинэчлэлийн хүрээнд төр шимтгэлийг нь хариуцдаг иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд иргэний хариуцан төлөх хамтын төлбөрөөс бүрэн чөлөөлсөн. Энэхүү зохицуулалтаар гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээс хойш 2022 онд 47 тэрбум, 2023 онд 62.8 тэрбум, 2024 онд 76.7 тэрбум төгрөгийг тус тус хамтын төлбөрөөс чөлөөлсөн байна.

Хүснэгт 36. Эмзэг бүлгийн хүн амыг хамтын төлбөрөөс чөлөөлсөн байдал (тэрбум.төг)

№	Хамтын төлбөрөөс чөлөөлөх бүлэг	МД	Хамтын төлбөрөөс чөлөөлсөн дүн		
			2022 он	2023 он	2024 он
А	Б	В	1	2	3
1	Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн–иргэн	1	3.26	7.34	8.67
2	Тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн	2	30.69	42.71	49.62
3	Ял эдэлж байгаа ялтан	3	0.05	0.04	0.04
4	0–18 насны хүүхэд	4	10.12	13.51	16.18
5	Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч	5	0.04	0.06	0.06
6	Хүүхдээ хоёр /ихэр бол гурав/ нас хүртэл өсгөн бойжуулж буй эх, эцэг	6	2.97	1.85	2.18
	Нийт (мөр 1:6)	**7**	**47.16**	**62.81**	**76.75**

3.Шаардлагагүй хэвтэлт, үр ашиггүй тусламж, үйлчилгээг бууруулах: Эрүүл мэндийн даатгалын сан бүх тусламж, үйлчилгээг худалдан авах боломжгүй учраас боломжит нөөцөөр нийт иргэн даатгуулагчийн эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг худалдан авах нь чухал байдаг. Иймд ЭМДҮЗ–ийн оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, журам батлах тухай тогтоолд нэн шаардлагатай амь нас аврах, даатгуулагчийг санхүүгийн эрсдэлд огцом оруулдаг тусламж, үйлчилгээг багцад бүрэн оруулах, шаардлагагүй, амьдралын чанарыг дээшлүүлэх чиглэлийн тусламж, үйлчилгээг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд Эрүүл мэндийн даатгалын сан нэн шаардлагатай тусламж, үйлчилгээнд түлхүү зарцуулагддаг болсон байна. Тодруулбал: Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлээс өмнө буюу 2020 онд ЭМД–ын сангийн 42.1 хувь нь шаардлагатай тусламж, үйлчилгээнд зарцуулагддаг байсан бол уг үзүүлэлт 2022 онд 71.8 хувь, 2023 онд 81.6 хувь, 2024 онд 84.2 хувь болж эрүүл мэндийн сангийн санхүүжилтийн үр ашиг нэмэгдсэн байна.

Зураг 7. Эрүүл мэндийн даатгалын сангийн үр ашгийн байдал



4.Тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах: Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлээс өмнө нэн шаардлагатай зарим тусламж, үйлчилгээ нь хүртээмжгүй, цөөн байгууллага дээр төвлөрсөнтэй холбоотойгоор тусламж, үйлчилгээний хүлээгдэл, ачаалал өндөр байсан.


Уг санхүүжилтийн шинэчлэл хэрэгжсэнээр хорт хавдрын мэс засал 6 дахин, хөнгөвчлөх эмчилгээ 43.5, хими, бай эмчилгээ 64.9 дахин хүртээмж нэмэгдсэн бол яаралтай тусламж үзүүлэх байгууллагын тоо 11.5 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 37. Зарим нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын тоо, харьцуулсан хувь

Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ	МД	2021 он	2022 он	2023 он	2024 он	Өсөлтийн хувь
А	Б	1	2	3	4	5
Хорт хавдар хими, бай	1	13	16	30	37	23.3%
Хорт хавдар хөнгөвчлөх	2	26	37	41	46	12.2%
Хорт хавдар мэс засал	3	5	20	38	39	2.6%
Гэмтлийн яаралтай тусламж	4	20	53	41	0	–100.0%
Гэмтлийн мэс засал		42	46	42	0	–100.0%
Яаралтай тусламж		54	62	61	61	0.0%

5.ЭМД–ын сангаас иргэнд тавьж байгаа санхүүгийн хязгаарыг арилгах: Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлээс өмнө ЭМД–ын сангаас жилд 2 сая төгрөг хүртэлх тусламж, үйлчилгээг даах, сард 55000 төгрөг хүртэлх оношилгоо шинжилгээ хийлгэх, давсан тохиолдолд иргэн өөрөө төлбөрөө төлөх зохицуулалттай байсныг 2020 оны багц хуулиар даатгуулагч эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлээ хамгаалуулах тогтолцоог бий болсон. Тодруулбал: 2021 онд 17.754 даатгуулагч, 2022 онд 27.273 даатгуулагч, 2023 онд 64.810 даатгуулагч, 2024 онд 142.207 даатгуулагчийн нийт төлбөр нь 2 сая төгрөг ба түүнээс дээш санхүүжилт бүхий тусламж, үйлчилгээг ЭМД–ын сангаас авсан байна. Хамгийн өндөр санхүүгийн хамгаалалт авсан даатгуулагч нь 2022 онд 126,9 сая төгрөг, 2023 онд 185,6 сая төгрөг, 2024 онд 202,8 сая төгрөгийн тусламж, үйлчилгээг тус тус авсан байна.

Зураг 8 Даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлсэн орлого, зардлын эзлэх хувь




2024 оны байдлаар эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтын 75.1 хувь нь төр шимтгэлийг нь хариуцан төлдөг даатгуулагч, 14.1 хувь нь цалин, түүнтэй адилтгах орлогоос шимтгэл төлж байгаа даатгуулагч, 10.7 хувь нь шимтгэлээ өрөө хариуцан төлдөг даатгуулагчийн авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд тус тус зарцуулагдсан байна.

Анхан шатны тусламж, үйлчилгээнд хамрагдагсад: 2024 онд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтын дагуу өрх, сум, тосгоны эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх зарим тусламж, үйлчилгээнд давхардсан тоогоор 1.6 сая даатгуулагчийг хамруулсан байна. Уг тусламж, үйлчилгээг авсан даатгуулагчийн шимтгэл төлөлтийн төрлөөр нь харвал 0–18 насны хүүхдүүд 35.9 хувь, тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэд 33.2 хувийг, ААН, төсөвт байгууллагын ажилтан 10.9 хувийг, нийгмийн халамж, дэмжлэг, туслалцаа, зайлшгүй шаардлагатай иргэд 9.3 хувийг, шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг иргэд 4.1 хувийг, хүүхдээ хоёр нас /ихэр бол гурав/ нас хүртэл нь өсгөн бойжуулж эх/эцэг 3.9 хувийг, малчид 1.8 хувийг, оюутан 0.8 хувийг тус тус эзэлж байна.


Тусламж, үйлчилгээний нэр төрлийг, даатгуулагчийн шимтгэл төлөлтийн төрлөөр ангилж үзвэл өдрийн тусламж, үйлчилгээг авсан даатгуулагчийн 50 хувийг тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэд, 14 хувийг ААН, төсөвт байгууллагын ажилтан, 14 хувийг 0–18 насны хүүхэд, 11 хувийг нийгмийн халамж, дэмжлэг шаардлагатай иргэд, 11 хувийг хүүхдээ хоёр нас /ихэр бол гурав/ нас хүртэл нь өсгөн бойжуулж эх/эцэг, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн тус тус авсан байна. 2024 онд өдрийн эмчилгээний багцыг өргөжүүлж зорилтот бүлгийн даатгуулагч болох 0–18 насны хүүхдүүдэд чиглүүлсэн нь үр дүн гарч эхэлсэн байна.

Зураг 9. Өдрийн эмчилгээний тусламж, үйлчилгээ авсан даатгуулагч, эрүүл мэндийн байгууллагын төрлөөр, шимтгэл төлөлтийн төрлөөр




Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн байгууллагаас гэрээр үзүүлэх тусламж тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчдыг шимтгэл төлөлтийн төрлөөр нь харвал тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэд 83 хувийг, 0–18 насны хүүхдүүд 10 хувийг, нийгмийн халамж, дэмжлэг, туслалцаа, зайлшгүй шаардлагатай иргэд 2 хувийг, ААН, төсөвт байгууллагын ажилтан 2 хувийг, хүүхдээ хоёр нас /ихэр бол гурав/ нас хүртэл нь өсгөн бойжуулж эх/эцэг, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч 3 хувийг тус тус эзэлж байна. Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмж жил бүр үе шаттайгаар нэмэгдэж байгаа ч зорилтот бүлэг болох эмнэлэгт ирэх боломжгүй иргэдэд хүрч үйлчлэх хэрэгцээ байсаар байна.

Зураг 10. 2024 онд гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчдыг шимтгэл төлөлтийн төрлөөр




Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас сэргээн засах тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчдыг шимтгэл төлөлтийн төрлөөр нь харвал тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэд 32 хувийг, 0–18 насны хүүхдүүд 39 хувийг, ААН, төсөвт байгууллагын ажилтан 11 хувийг, нийгмийн халамж, дэмжлэг, туслалцаа, зайлшгүй шаардлагатай иргэд 8 хувийг, хувиараа хөдөлмөр эрхэлж буй иргэд болон хүүхдээ хоёр нас /ихэр бол гурав/ нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх/эцэг 4 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 11. 2024 онд сэргээн засах тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчдыг шимтгэл төлөлтийн төрлөөр



Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд оношилгоо, шинжилгээний тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчдыг шимтгэл төлөлтийн төрлөөр нь харвал тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэд 29 хувийг, 0–18 насны хүүхдүүд 39 хувийг, ААН, төсөвт байгууллагын ажилтан 11 хувийг, нийгмийн халамж, дэмжлэг, туслалцаа, зайлшгүй шаардлагатай иргэд 10 хувийг, хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа иргэд болон хүүхдээ хоёр нас /ихэр бол гурав/ нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх/эцэг 4 хувийг, малчин 2 хувийг, оюутан 1 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 12. 2024 онд оношилгоо, шинжилгээ хийлгэсэн даатгуулагчдыг шимтгэл төлөлтийн төрлөөр



Анхан шатны тусламж, үйлчилгээний хувьд хүн амын хамралт нь тохиолдлын тооноос илүү чухал байдаг бөгөөд гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, сэргээн засах, оношилгоо шинжилгээг хэрэгцээтэй иргэдэд нь үзүүлж, лавлагаа шатлалын ачааллыг бууруулахад ач холбогдолтой байдаг. Иймээс анхан шатны тусламж, үйлчилгээний багцыг оновчтой болгож өргөжүүлэх, сайжруулах, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын цахим систем дэх бүртгэлийг хөнгөвчлөх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч ажиллаж байна.


Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээнд хамрагдагсад: Лавлагаа зарим тусламж, үйлчилгээнд давхардсан тоогоор 11.1 сая даатгуулагчийг хамруулсан байна. Тусламж, үйлчилгээг авсан даатгуулагчийн шимтгэл төлөлтийн төрлөөр нь харвал тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэд 32.3 хувийг, 0–18 насны хүүхдүүд 27.1 хувийг, ААН, төсөвт байгууллагын ажилтан 15.7 хувийг, нийгмийн халамж, дэмжлэг, туслалцаа, зайлшгүй шаардлагатай иргэд 10.3 хувийг, шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг иргэд 6.8 хувийг, хүүхдээ хоёр нас /ихэр бол гурав/ нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх/эцэг 4.9 хувийг, малчид 1.5 хувийг, оюутан 1.4 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 13. 2024 онд лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчдыг шимтгэл төлөлтийн төрлөөр




Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээнд хамрагдсан нийт даатгуулагчийн хамгийн өндөр хувийг тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн эзэлж байна.

Зураг 14. 2024 онд лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээнд хамрагдсан тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэд болон 0–18 насны хүүхдийн авсан тусламж, үйлчилгээний нэр төрөл, эзлэх хувь




Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн тусламж, үйлчилгээнд хамрагдагсад: Нийт илрүүлэг оношилгоо, шинжилгээнд хамрагдсан даатгуулагчийг насны ангиллаар харвал 16 хувийг 31–45 нас, 8 хувийг 46–60 нас, 10 хувийг 61–ээс дээш насны даатгуулагч эзэлж байгаа ба хамгийн бага хамрагдалт буюу 7 хувийг 18–30 насныхан байна.

Зураг 15. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн хамрагдалтын хувь, нас, нийт хүн амаар



Эрт илрүүлгийн тусламж, үйлчилгээнд ажил хөдөлмөр эрхэлдэг буюу цалин, түүнтэй адилтгах орлогоос шимтгэл төлдөг иргэн 24.2 хувь, тэтгэврийн иргэн 28.1 хувь, нийгмийн халамж, дэмжлэг шаардлагатай бүлгийн иргэн 16.8 хувь, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн 12.1 хувийг тус тус эзэлж байгаа бол малчид, оюутнууд, хүүхдээ хоёр нас /ихэр бол гурав/ нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх/эцэг, хүүхдийн хамрагдалт хангалтгүй байна.

Зураг 16. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээний хамрагдалт, даатгуулагчийн төрөл



Эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдагсад: Хөнгөлөлттэй эм авч байгаа нийт даатгуулагчийн 51 хувийг тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй даатгуулагч буюу 2 даатгуулагч тутмын 1 нь өндөр настан байна.

Хүснэгт 38. Эмийн үнийн хөнгөлөлт, даатгуулагчийн төрлөөр (сая.төг)

Даатгуулагчийн төрөл	мд	2022 он		2023 он		2024 он	
		Тохиолдлын тоо	Санхүүжилт	Тохиолдлын тоо	Санхүүжилт	Тохиолдлын тоо	Санхүүжилт
А	Б			1	2	3	4
Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн–иргэн	1	183,155	3,858.70	216,297	4,623.90	327,265	7,754.20
Гадаадын иргэн, харьяалалгүй хүн	2	353	8.4	466	12	1460	41.1
Малчин	3	45,322	931.8	54,298	1,207.10	74,838	1,846.80
Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт–үйлдвэрлэлийн төвийн суралцагч	4	3,177	74.6	4,908	121.7	27,755	776.9
Сайн дур	5	198,067	4,712.90	237,858	6,048.70	286,865	8,333.50
Тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн	6	2,828,585	60,392.30	3,105,987	66,875.90	3,680,214	91,820.10
Ял эдэлж байгаа ялтан	7	31	0.6	33	0.3	54	1.1
0–18 насны хүүхэд	8	71,117	856.6	87,531	1,991.40	154,795	3,505.80
Цалин	9	533,243	12,577.80	545,170	13,408.20	636,136	18,254.00
Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч	10	86	2.3	96	1.5	120	2.6
Хүүхдээ хоёр /ихэр бол гурав/ нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх /эцэг/	11	40,161	835.5	63,309	1,393.60	92,909	2,221.30
Нийт дүн (мөр 1:11)	**12**	**3,903,297**	**84,251.60**	**4,315,952**	**95,684.60**	**5,282,411**	**134,557.30**

6 СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, ГЭРЭЭЛЭЛТ

